



# ОНЦГОЙ МЭДЭЭ

2023 оны есдүгээр сар

№ 18 (195)

14 хоног тутмын хэвлэл

V НҮҮРТ



**АЗ ЖАРГАЛ  
БЭЛЭГЛЭГЧ**

VI, VII НҮҮРТ



**УЛСЫН ХЭМЖЭЭНД ТОХИОЛДСОН  
ОБЪЕКТЫН ТОМООХОН  
ГАЛ ТҮЙМРҮҮД**

XII НҮҮРТ



**ТҮҮХЭН ДЭХ ХАМГИЙН  
ХҮЧИРХЭГ ГАЛ УНТРААХ  
АВТОМАШИН**

**ОНЦЛОХ МЭДЭЭЛЭЛ**

**ДУГААР ЭРХЛЭГЧИЙН  
ЗУРВАС**



Эрхэм уншигчдынхаа энэ өдрийн амгаланг айлтгая.

"Онцгой мэдээ" сонин Онцгой байдлын байгууллагын түүхийн товчоо, алба хаагч бидний итгэл бахархлын гэрч болсоор ирсэн билээ. Он цагийн архив, соён гэгээрүүлэх эрхэм үүрэгтэй сонинхоо энэ удаагийн дугаарыг Гал түймэртэй тэмцэх газраас эрхлэн гаргаж байгаа нь шинэ содон бөгөөд нэр хүндтэй ажил байлаа.

"Бид та бүхэндээ "Галын аюулгүй байдлын мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүний ажиллах журал", "Гал түймрийн улсын хяналтын дүрэм"-д Засгийн газрын тогтоолоор орсон нэмэлт өөрчлөлтүүдийг танилцуулж байна.

Мөн гал түймэртэй тэмцэх чадавхыг бэхжүүлэх садааг хамтын ажиллагааны танилцуулга, онцгой байдлын байгууллагад ашиглагдаж буй орчин үеийн гал түймэр унтраах тусгай тоноглол бүхий автомашин, техникээ сонирхуулаа.

Түүнчлэн манай улсад сүүлийн 10 жилд тохиолдсон томоохон объектын гал түймрийн мэдээллийг бэлтгэн хүргэж байна. Олон улсын гал сөнөөгч аврагчдын холбооноос Бүгд найрамдах Турк улсын Истанбул хотноо зохион байгуулсан гал унтраах техникийн олон төрөлт спортын дэлхийн аварга шалгаруулах 19 дэх удаагийн тэмцээний талаарх мэдээлэл, эрдэм шинжилгээний нийтлэл, хамгийн анхны эмгэгтэй аврагч, гал сөнөөгчийн талаар болон бусад сонирхолтой, мэдээ мэдээллийг ч багтаалаа.

Мэдээллийн дэлгэрэнгүйг QR кодын тусламжтай дүрс бичлэгээр үзэх боломжийг бүрдүүлсэн нь шинэлэг болсон гэдэгт найдаж байна.

Та бүхний гэгээн үйлсийн зам үргэлж гэрэлтэй гарган байх болтугай.

**ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ  
ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА  
Ц.НЯМБАЯР**



**“ Хил орчмын нутаг дэвсгэрт улс дамнасан гамшиг, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих зорилгоор баталсан журмын дагуу мэдээлэл солилцоход онцгойлон анхаарна. Мөн алба хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулах, аврах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх сэтгэлзүйч бэлтгэхэд хамтран ажиллахаар тохиролцов.**

Монгол-Оросын хамтарсан комиссын XIX хуралдааны тэмдэглэлээс...

**ХИЙ ДАМЖУУЛАХ ХООЛОЙ, НЕФТЬ, ХИМИЙН БАЙГУУЛАМЖИД ГАРСАН  
ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР СУРГАЛТАД ХАМРУУЛНА**

ОХУ-ын Иргэний хамгаалалт, онцгой байдал, байгалийн гамшигийн үр дагаврыг арилгах асуудал эрхэлсэн сайд, дэслэгч генерал А.В.Куренков тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад хүрэлцэн ирэв. Энэ үеэр үйлдвэрийн осол, байгалийн гамшигаас урьдчилан сэргийлэх, түүний хор уршгийг арилгах салбарт хамтран ажиллах тухай Монгол болон ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх "Монгол-Оросын хамтарсан комиссын XIX хуралдаан" боллоо. Хуралдааны нээлтэд ОБЕГ-ын дарга, хошууч генерал Г.Ариунбуян монгол, оросын ард түмний олон жилийн найрамдалт харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд 1995 онд байгуулагдсан Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх, хоёр орны онцгой байдлын салбар дахь харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд

хамтарсан комиссын хуралдаан зохих үр дүнгээ өгч, хоёр улсын хил залгаа бүс нутаг, аймгийн хүрээнд өргөжин тэлж байгааг онцоллоо. Мөн Монгол Улсын Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, чадварлаг боловсон хүчнийг бэлтгэх тал дээр ОХУ-ын Онцгой байдлын яамны зүгээс онцгойлон анхаарлаа хандуулсанд талархал илэрхийлэв.

Хамтарсан комиссын хуралдаанаар Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар, ОХУ-ын Иргэний хамгаалалт, онцгой байдал, тэдгээрийн хор уршгийг арилгах яам хоорондын 2024-2025 оны хамтын ажиллагааны төлөвлөгөөг баталлаа. Тус төлөвлөгөөнд Монгол, Орос, Хятад гурван улсын гал түймэр унтраах, аврах албаны олон улсын дадлага сургуулийг зохион байгуулах, Монгол Улсын Онцгой

байдлын алба хаагчид Олон улсын гал түймэр унтраах, аврах ажиллагааны IV их хуралд оролцох, хий дамжуулах хоолой, нефть, химийн байгууламжид гарсан гал түймэртэй тэмцэх чиглэлээр хамтарсан сургалтууд зохион байгуулах ажлуудыг тусгасан байна.

Түүнчлэн Хил орчмын нутаг дэвсгэрт хил дамнасан гамшиг, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих зорилгоор баталсан Шуурхай мэдээлэл солилцох журамд заасны дагуу мэдээлэл солилцоход онцлон анхаарах, алба хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулах, аврах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх сэтгэлзүйч бэлтгэх сургалтуудыг хамтран зохион байгуулахаар тохиролцлоо. Монгол-Оросын хамтарсан комиссын XX хуралдааныг 2025 онд ОХУ-д зохион байгуулахаар тогтов.

**ШИЛДГИЙН ШИЛДГЭЭР ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ЭРЭН ХАЙХ,  
АВРАХ АНГИЙН АВРАГЧ-УСЧИН, АХЛАГЧ П.СҮХБАТ ШАЛГАРЛАА**



Онцгой байдлын байгууллагын нийслэл, дүүрэг, 21 аймгийн шилдгийн шилдгүүдийн "Залуу ахлагч нарын цуглалалт-2023" болов. Үүнд 180 гаруй алба хаагч оролцож, цэргийн хэргийн болон гадаад хэлний мэдлэг, буудлагын тэмцээн, бие бялдрын бэлтгэлжилт, багаар ажиллах чадварын тэмцээн гэсэн нийт таван төрлөөр мэдлэг, оюун ухаан, хурд хүчээ сорин өрсөлдсөн юм.

Нийлбэр дүнгээр эрэгтэйчүүдийн төрөлд Дорнод аймгийн Онцгой байдлын газрын Эрэн хайх, аврах ангийн аврагч-усчин, ахлагч П.Сүхбат, эмэгтэйчүүдийн төрөлд Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 16 дугаар ангийн дуудлага хүлээн авагч, ахлах ахлагч Б.Ганзаяа нар бусдыгаа манлайлан шилдгийн шилдгээр шалгарлаа.

Харин бие бялдрын бэлтгэлжилт тэмцээний төрөлд,

эрэгтэй- Дорнод аймгийн Онцгой байдлын газрын Эрэн хайх, аврах ангийн аврагч-усчин, ахлагч Пүрэвсүрэнгийн Сүхбат, эмэгтэй-Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын Эрэн хайх, аврах салбарын аврагч усчин, ахлах ахлагч Цогтбаатарын Балжинням, Буудлагын тэмцээний төрөлд эрэгтэй- нийслэлийн Онцгой байдлын газрын Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 10 дугаар ангийн гал сөнөөгч, ахлагч Базарын Кеншилик, эмэгтэй-Тэргүүн байранд Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 16 дугаар ангийн дуудлага хүлээн авагч, ахлах ахлагч Бат-Эрдэнийн Ганзаяа, Гадаад хэлний төрөлд эрэгтэй- нийслэлийн Онцгой байдлын газрын Аврах ангийн аврагч, дэд ахлагч Мөнх-Очирын

Мөнгөнжавхаа эмэгтэй- 113 дугаар ангийн бичиг хэрэг, архивын эрхлэгч, ахлагч Батбаярын Хорлоогарав, Цэргийн дүрмийн мэдлэг төрөлд эрэгтэй- Төв аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 24 дүгээр ангийн аврагч-гал сөнөөгч, ахлагч Батсайханы Жамба, эмэгтэй- Төв аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 24 дүгээр ангийн дуудлага хүлээн авагч, ахлагч Бадамсүрэнгийн Батчимэг нар тус тус тэргүүлж шагналаа гардан авав. Багаар ажиллах чадвар тэмцээний төрөлд тэргүүн байрыг нийслэлийн Онцгой байдлын газрын Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн ахлагч нарын баг, дэд байрыг Дорнод аймгийн Онцгой байдлын газрын ахлагч нарын баг, гуравдугаар байрыг Увс аймгийн Онцгой байдлын газрын ахлагч нарын баг эзэлсэн байна.

### ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАН БАТЛУУЛАВ

Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2022 оны арваннэгдүгээр сарын 11-ний өдөр батлагдаж 2023 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн.

Мөн түүнчлэн Засгийн газрын 2022 оны арванхоёрдугаар сарын 21-ний өдрийн 469 дүгээр тогтоолоор Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын яамдад шинжсэнтэй холбогдуулан Засгийн газрын 2016 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан "Гал түймрийн улсын хяналтын дүрэм"-д нэмэлт, өөрчлөлт оруулж Засгийн газрын 2023 оны 247 дугаар тогтоолоор батлууллаа.

Гал түймрийн улсын хяналтын дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулснаар төрийн тусгай чиг үүрэг бүхий цэргийн байгууллага хүсэлт гаргасан тохиолдолд галын аюулгүй байдлын чиглэлээр мэргэжил эзэмшсэн албан хаагчид зөвхөн тухайн байгууллагын хэмжээнд гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх хяналтын байцаагчийн

эрх олгох боломж бүрдэж байна. Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн эрх олгох шалгалтыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зохион байгуулж, тэнцсэн албан тушаалтанд үнэмлэх, энгэрийн тэмдэг, баталгааны тэмдэг олгохоор тусгасан байна.

Мөн түүнчлэн Төрийн хяналт шалгалтын тухай хууль, техникийн зохицуулалт шинэчлэн батлагдсантай холбогдуулан хяналтын байцаагч нь үйл ажиллагаандаа Галын аюулгүй байдлын тухай, Төрийн хяналт шалгалтын хууль тогтоомж, техникийн зохицуулалт энэхүү дүрмийг удирдлага болгож галын аюулгүй байдлын шаардлагыг тодорхойлсон техникийн зохицуулалт, норм, нормативын хэрэгжилтэд хяналт тавихаар тусгасан байна.

Хяналтын байцаагч нь галын аюулгүй байдлын шаардлагыг тодорхойлсон техникийн зохицуулалт, норм, нормативын хэрэгжилтэд хяналт тавихаар тусгасан байна.



QR уншуулж нэмэлт өөрчлөлт оруулсан "Гал түймрийн улсын хяналтын дүрэм"-тэй танилцана уу.

### BACKDRAFT ГЭЖ ЮУ ВЭ

Хойд Америкийн англи хэл "Backdraft" харин Британийн англи хэлээр "Backdraught" гэж бичигддэг back + draft гэсэн хоёр үгнээс гаралтай бөгөөд өнөөдөр олон улсын хэллэг болсон байна.

Уг үгний тодорхойлолт нь битүү орчин дахь халсан шатамхай хий хүчилтөрөгчтэй гэнэт холилдоны улмаас үүсэх дөлтэй тэсрэлт (тургилт) явагдах үзэгдэл.

Өөрөөр хэлбэл битүү орчинд гал түймэр гарсны улмаас их хэмжээний дулаан, шатах хий хуримтлагдсан нөхцөлд гаднаас агаар ихээр орж ирэх үед агаартай холилдон шатах хий гал түймрийн эх үүсвэрийн нөлөөгөөр хоромхон зуур тэсрэлтийн шинжтэй огцом шатах үйл явц юм.

Дэлхийн өндөр хөгжилтэй улс

орнуудын гал түймэртэй тэмцэх байгууллагууд "Backdraft"-ын талаар судлахын зэрэгцээ алба хаагчдадаа ойлгуулах, аюулгүй байдлыг хангах зорилгоор зохиомол орчинд дадлага, сургалтуудыг явуулдаг.

Битүү орчинд гарсан гал түймэр нь гаднаас агаар (хүчилтөрөгч) орохгүй байгаа тохиолдолд орчны температур буурч, шаталт эрс суларч унтаа байдалд шилжиж эхлэх ба улмаар унтардаг. Өрөөний температур буурсан буюу хэт бага үед хаалга, цонхыг онгойлгоход дээд хэсгээр утаа гарч, дотор хэсгээр агаар орсноор гал дахин асаж, хөгжих ба "Backdraft" үүсэхгүй.

Харин өрөөний температур их үед гаднаас огцом агаар орж халуун шатах хий агаартай холилдож байгаа холимгийн бүсэд "Backdraft" үүсдэг.

Backdraft-ын видео бичлэг үзэж дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл доорх QR кодыг уншуулна уу.



### ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН, АЖИЛЛАХ ЖУРМЫГ ШИНЭЧИЛЛЭЭ

Монгол Улсын Шадар сайдын 2017 оны гуравдугаар сарын 23-ны өдөр 30 дугаар тушаалаар "Галын аюулгүй байдлын мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн", "Галын аюулгүй байдлын мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам"-ыг баталсан билээ.

Тэгвэл Зөвшөөрлийн тухай хуулийг энэ оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн ба түүнтэй нийцүүлэн Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт орж, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг татан буулгасантай холбогдуулан дээрх журамд


шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг оруулан Монгол Улсын Шадар сайдын 2023 оны тавдугаар сарын 30-ны өдрийн 39 дүгээр тушаалаар батлууллаа.

Галын аюулгүй байдлын мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн 11 гишүүнтэй байх бөгөөд зөвлөлийг Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын дарга удирдахаар болж байна. Мөн дээрх зөвлөлд Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн Гал түймэртэй тэмцэх албаны тэнхимийн эрхлэгч гишүүнээр нэмэгдсэн онцлог байна.



QR уншуулж нэмэлт өөрчлөлт оруулсан "Гал түймрийн аюулгүй байдлын мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам"-тай танилцана уу.


### ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ




Улсын хэмжээнд 2023 онд Монгол Улсын Шадар сайдын баталсан 5, Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан 7 удирдамжийн хүрээнд урьдчилан сэргийлэх болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулсан. Хяналт шалгалтад иргэн хуулийн

этгээдийн 10.421 барилга байгууламж, 105.011 айл өрхийг хамруулан 82.717 зөрчлийг илрүүлж, 44.684 зөрчлийг газар дээр нь арилгуулж, нийт 233 иргэн, хуулийн этгээдэд 239.850.000 төгрөгийн торгуулийн шийтгэл оногдуулсан байна.

#### ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХҮРЭЭНД



#### ГАЛ ТҮЙМРИЙН ШАЛТГААН




**НЭГ. ТҮҮХИЙН ХУУДАСНАА.**

Хүн анх үрэлтийн тусламжтайгаар гал гаргаж авсан явдал нь хүн төрөлхтний түүхэнд аугаа их нээлт болсны зэрэгцээ мөн төдий хэмжээний гай гамшиг учруулсан байдаг. Гал түймэр гарч орон байр, идэш тэжээл, хөдөлмөрийн багаж зэвсгийг бүхэлд нь устгаж байжээ. Иймээс хүн гал түймрээс хамгаалах арга замыг дээр үеэс хайж эхэлсэн байна. Түүхэн тэмдэглэлээс харахад анхны аврах багууд эртний Египет, Ромын эзэнт гүрэнд байгуулагдаж гал түймэртэй тэмцдэг байжээ.

Манай улсын хойд хөрш Оросын холбооны улсад XI зууны төгсгөл үеэс гал түймэртэй идэвхтэй тэмцэж эхэлсэн байдаг. Анхны гал унтраах анги нь таван зууны дараа буюу тодруулбал 1504 онд байгуулагдаж байсан. Энэ үед сүх, дүнээр зэвсэглэсэн цэргүүдийн эскадриль байв. Гал сөнөөгч хэмээх



**ГАЛ СӨНӨӨГЧ БАЙГАЛИЙН УХААНЫ ОНОЛ ПРАКТИКИЙН ӨРГӨН МЭДЛЭГТЭЙ БАЙХ ЁСТОЙ**



мэргэжил 1649 оны дөрөвдүгээр сарын 30-нд үүссэн гэж албан ёсоор үздэг. Яг энэ өдөр Алексей Михайлович хаан "Наказ о Градском благочинии" нэртэй зарлиг гаргаж Москва хотод гал сөнөөх үүрэгтэй байнгын жижүүрийн албыг бий болгож байжээ.

**ХОЁР. МАНАЙ УЛСАД**

Монголчууд эрт дээр үеэс гал түймэртэй тэмцэх өвөрмөц аргуудтай, нүүдэлчдийн соёл иргэншилд тохирсон энгийн технологитой, гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэх тогтсон хэв заншилтай байжээ. Тухайлбал, монголын түүхийн болон Монгол хууль цаазын нэн чухал түүхэн баримт бичиг болох эзэн Чингис хааны "Их засаг" хуулийн 34 дүгээр зүйлд, "зарлиг зааваргүйгээр эвдлэн шатаасдыг алах ялаар шийтгэмж. 51 дүгээр зүйлд, "өвс ногоорсон хойно газрыг нүхэлсэн ба

гал алдаж бэлчээрийг шатаасны нэгэн гэрийг алмой". Халх журам хуулийн есдүгээр бүлгийн 176 дугаар зүйлд, "хэн хүн түймэр алдвас хэдэн хүн ч байсан хүн тус бүрээр торго, алдагч хүн өөрөө унтрааваас торгуульгүй, гэрчилбээс гэрчлэгч хүн морь ав". 177 дугаар зүйлд, "улсын дунд түймэр шатааваас түймрийг аль ойр байгаа нь зартай заргүй унтраана, зар сонссон байж ноён хүн эс мордвоос морь ав, ямбатан сайд дарга нараас үхэр ав, энгийн хүнээс хонь ав. Хэн хүн зар тасалбаас энэ зэргээр баалж бай. Хүн үхвээс хүн алсны анзуу болоод артай. Ямбат хүн түлэгдээд эдгэвэл тэмээ, морь хоёр өг. Ямбагүй бол морь өг. Хэн хүн нүүсэн нутгийнхаа галыг унтраа, эс унтрааваас шүдлэн морь авч бай" гэж хуульчлан тогтоосон нь монголчууд гал түймэртэй тэмцэх асуудлыг эртнээс анхаарч ирсний тод илрэл юм.

Орчин цагийн гал түймэртэй тэмцэх байгууллага нь Ардын засгийн газрын 1922 оны нэгдүгээр сарын 13-ны өдөр хуралдсан 35 дугаар хуралдаанаар Орос, Хятад худалдааны газрын мэдэлд байсан усан хөөргийг шилжүүлэн авч, "Гал эсэргүүцэн сөнөөх алба" -ыг байгуулсан түүхтэй.

Монгол хэлний тайлбар толь "Гал сөнөөгч" гэж галын аюулыг унтраах ажил мэргэжил бүхий хүн гэж заасан байдаг.

Гал сөнөөгч нь байгалийн ухааны болон гал түймэр, гамшиг осолтой

тэмцэх, урьдчилан сэргийлэх онолын болон практикийн өргөн мэдлэгтэй байх ёстой. Үүнээс гадна бусадтай харилцах, манлайлах ур чадвартай, ажлын ачаалал даах, албаны болон хувийн нууцыг хадгалах үүрэг хүлээнэ. Гал сөнөөгч ой тогтоолт, анхаарал төвлөрөлт сайтай, сэтгэн бодох чадвартай, хурдан шуурхай, гар болон нүдний баримжаатай, гарын эв дүйтэй, техник сэтгэлгээтэй. Сэтгэл хөдлөлөө хянах, бие дааж болон багаар ажиллах чадвартай байх ёстой.

Статистик судалгаанаас үзэхэд Монгол Улсын хэмжээнд 1500 хүн тутамд нэг гал сөнөөгч үйлчилдэг. Энэ нь 1500 хүн тутмын нэг нь гал сөнөөгч мэргэжилтэй байна гэсэн үг юм.

харьяалалгүй алба хаагчийг томилон ажиллуулбал түүнд албан тушаалын үндсэн цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдлийг улирал тутамд олгодог, алба хаагчийн гэр бүлийн гишүүн цэргийн эмнэлгээр үйлчлүүлдэг, гадаадын цэргийн сургуульд суралцагч офицер, ахлагч нь цэргийн алба хаах хугацаанд болон тэтгэвэрт гарсан үедээ хууль тогтоомжоор тогтоосон нөхцөл, журмын дагуу эмнэлгийн үйлчилгээнд хамрагддаг, эмнэлгийн үйлчилгээний төлбөрийг төр хариуцдаг гэх мэт дурдаад байвал давуу тал их байдаг.

Мэдээж юм бүхэнд сул тал гэж

Монголын биеийн тамир спортын төв зөвлөлийн тэргүүлэгчдийн 1971 оны дөрөвдүгээр сарын 29-ний өдрийн тогтоолоор гал унтраах техник спортыг БНМАУ-ын /хуучин нэрээр/ спортын нэгдсэн ангилалд оруулж, тамирчдад олгох зэргийн болзлыг баталсан байна.

Манай баг тамирчид хуучин социалист орнуудын галын байгууллагуудын баг тамирчдын дунд зохион байгуулдаг олон улсын тэмцээнд анх 1973 онд Болгар улсад зохиогдоход анх оролцсон бөгөөд түүнээс хойш 1986 он хүртэл тасралтгүй оролцсон байна.

Гал унтраах техникийн олон төрөлт спортын холбоо нь батлагдсан дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа



**ХАМГИЙН АНХНЫ ЭМЭГТЭЙ ГАЛ СӨНӨӨГЧ Д.ЧУЛУУНХҮҮ**



Энэ явдал тэртээ 1959 оны нэгдүгээр сарын 1-ний өдөр Дорноговь аймагт болж өнгөрчээ. Өвлийн тэр нэгэн өдөр 12 настай Д.Чулуунхүү охин гэрээсээ гарч явтал нэг айлын тооноор өтгөн утаа гарах нь харагдаж, нялх хүүхдүүд уйлах нь сонсогдов гэнэ. Охин бодох санах юмгүйгээр шууд л шатаж буй айлын хаалгыг онгойлгон ороход эзэнгүй айлын шинэ жилийн сүлд модны утаснаас гал авалцаж, ойр орчмын зүйлс дүрэлзэн асч байж. Чулуунхүү охин гэрт уйралдан байсан гурван нялх хүүхдийн нэгийг нь тэвэрч, хоёрыг нь хөтлөн гал, утаан дундуур гарчээ. Гүйж орсон болон, аваргдсан нялх үрсийн нүүр, нуруу хайрагдаж, сэвлэг үс, хувцас нь шатаж, түлэгдсэн байв. Гэхдээ л дөрвөн нялх үрс эсэн мэнд гарсан юм.

Тухайн үед БНМАУ-ын АИХ-аар "Шударга журам" медалийг хэлэлцэн баталж, анхны медалиар зоригт охин Д.Чулуунхүүг шагнаж улмаар бяцхан охиныг нийслэл орон нутгийн дунд сургуулиудаар яриа хийлгэх, хэвлэл мэдээллээр сурталчлах зэргээр улс орон даяар алдаршуулсан байна. Энэ тухай 1990-ээд оныг хүртэл дунд сургуулийн хичээлээр зааж, ой тойнд ортол сурталчилж байсныг тэр үед сурагч байсан хүмүүс андахгүй санаж буй биз ээ.

Бусдын амь амьдралыг аварсан бахархал нь түүний ирээдүйг ч өөрчилсөн байна. Тэрбээр 1981 онд Гал унтраах байгууллагын босгыг алхан орж, эх орон ард түмнийхээ аюулгүй байдлыг сахин хамгаалах албанд 20 жил зүтгээд "Онц гал сөнөөгч" болж, Онцгой байдлын байгууллагаас цэргийн гавьяаныхаа амралтад гарсан байна.

Сүүлийн 10 жилийн судалгаанаас үзэхэд улсын хэмжээнд жил дунджаар 3800 орчим объектын, 110 орчим ой, хээрийн гал түймэр гарч байна. Энэ нь хоногт дунджаар 15 гал түймэр гарч байна гэсэн үг юм. Дээрх гал түймрийн дийлэнх хувь нь Улаанбаатар хотод бүртгэгддэг байна. Улаанбаатар хотын хувьд гал түймэр унтраах, аврах ангиудад хоногт 150 орчим гал сөнөөгч үүрэг гүйцэтгэдэг. Улаанбаатар хотын гал түймэр унтраах, аврах анги өдөрт нэг удаа гал түймрийн дуудлагаар гарч ажилладаг гэж ойлгож болохоор байна. Гал сөнөөгч нар хуулийн дагуу 24 цаг ажиллаж 72 цаг амардаг. Тэгэхээр 72 цаг тутамд нэг удаа гал түймрийн дуудлагаар гарч ажилладаг байна.

**ГАЛ СӨНӨӨГЧИЙН АЛБАН ҮҮРГЭЭ ГҮЙЦЭГТЭХ БАТАЛГАА, ШАГНАЛ УРАМШУУЛАЛ**

Гамшгаас хамгаалах тухай хууль, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар алба хаасан хугацааг тооцохдоо алба хаасан зургаан сар тутмыг найман сард дүйцүүлэн тооцдог, онцгой гавьяа байгуулсан тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100 дахин хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх мөнгөн урамшуулал олгодог, Алслагдсан аймаг, сумын нутаг дэвсгэрт байрлах онцгой байдлын байгууллагын харьяа нэгжид тухайн аймгийн

байдаг. Магадгүй гол сул тал бол байнгын эрсдэл, стресс юм. Хэдийгээр хүн хэчнээн хүчтэй мэт санагдаж байсан ч эрт орой хэзээ нэгэн цагт ийм ачаалал нь түүний сэтгэлзүүд нөлөөлдөг. Түүнчлэн, олон гал сөнөөгчид цалин хөлсийг сул талуудтай холбодог. Гэсэн хэдий ч гал сөнөөгчийн мэргэжил өөрийн гэсэн ач холбогдолтой. Гал сөнөөгч нар дор бүр амьдралаа эрсдэлд оруулж, бусдын амь нас, эд хөрөнгийг аварч хүмүүст аз жаргал бэлэглэдэг билээ.

**МЭРГЭЖЛИЙН СПОРТ**



Манай улсад 1956 оноос эхлэн гал сөнөөгчдийн гал унтраах ур чадвар, дэдлагыг дээшлүүлэх, гал унтраах үйл ажиллагааг сайжруулах зорилгоор уралдаан тэмцээнийг зохион байгуулдаг болжээ.

явуулж байгаа бөгөөд нийт улсын хэмжээнд таван клуб, 3000 гаруй гишүүнтэй нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага болсон байна. Тус холбоонд улсын шүүгч, гал унтраах техник спортын олон улсын хэмжээний мастер, спортын мастер, дэд мастер, I, II, III зэрэгтэй алба хаагч нар хичээллэдэг бөгөөд улсын аварга, бүсийн аваргын тэмцээнийг зохион байгуулж аваргаа шалгаруулдаг байна.

Гал сөнөөгчийн мэргэжил нь хүнээс тодорхой чанаруудыг шаарддаг. Гал сөнөөгчийн ажил, мэргэжил хүнд. Хүмүүс гал сөнөөгчдийн амьдралыг сайн мэддэггүй болохоор ойлгодоггүй юм шиг санагддаг. Тэд өөрсдөө бид хэцүү ажил хийж байна гэж хэзээ ч хэлдэггүй. "Цэрэг хүнийг 1000 өдөр тэжээж, нэг өдөр ачийг нь үз" гэдэг. Гал түймэр гараагүй үед тэдний албыг зарим хүмүүс, амар хялбар ажилтай хүмүүс гэж бодож, үнэлдэг юм шиг байдаг. Гал сөнөөгч хийнэ гэдэг амаргүй, амь насанд халтай, гал сөнөөгчийн ажлыг бүх хүн сайн мэдэж ойлгох учиртай. Гал сөнөөгчдийн амьдрал нь эгэл жирийн л байдаг.

Авралын дуудлагаар зэрэг боссон Ассан галын сөрөг зогссон Гал сөнөөгчийн хатан зориг Гамшиг халсан мөнхийн хориг



## ОЛОН УЛСЫН ГАЛ СӨНӨӨГЧ, АВАРГЧДЫН ХОЛБОО



Олон улсын гал сөнөөгч, аврагчдын спортын холбоог Дэлхийн гал түймэр унтраах, аврах албаны дарга нарын I бага хурлын шийдвэрээр 2001 онд байгуулсан. Дэлхийн 28 орны гал сөнөөгч, аврагчдыг нэгтгэдэг байгууллага юм.

### УДИРДЛАГУУД



**ЧУПРИЯН АЛЕКСАНДР ПЕТРОВИЧ**  
Ерөнхийлөгч



**ГОМБОЖАВЫН АРИУНБУЯН**  
Монгол Улсыг төлөөлсөн дэд ерөнхийлөгч



**КАЛИНИН АНДРЕЙ ПЕТРОВИЧ**  
Гүйцэтгэх захирал

### ҮНДСЭН ЗОРИЛГО

- Гал сөнөөгч, аврагчийн спортыг олон улсын түвшинд сурталчлах, хөгжүүлэх;
- Холбооны спортын үндсэн арга хэмжээний хуанлид багтсан дэлхийн болон Европын аварга шалгаруулах тэмцээн, олон улсын бусад тэмцээнийг зохион байгуулах, явуулах;
- Галын техникийн зэвсэг, тоног төхөөрөмжийн хамгийн сүүлийн үеийн технологийг нэвтрүүлэх;
- Дэлхийн улс орнуудын гал түймэр унтраах, аврах албадын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх;
- Мэргэжилтнүүдийн мэргэшлийг дээшлүүлэх, шүүхийн болон сургалтын семинар, зөвлөгөөн гэх зэрэг ажлыг зохион байгуулах, явуулах;
- Хувийн болон багийн аль алинд нь дэлхийн дээд амжилт, спортын хамгийн өндөр амжилтыг бүртгэх

## БНХАУ-ЫН ХАРБИН ХОТОД АРАВДУГААР САРЫН 26-28-НЫ ӨДРҮҮДЭД БАГА ХУРАЛ ХУРАЛДАНА

Олон улсын гал сөнөөгч, аврагчдын спортын холбооны гишүүн орнуудын Гал түймэр унтраах, аврах албаны дарга нарын олон улсын I бага хурал нь 2001 онд анх хуралдаж тус холбоог байгуулж байсан. Тус бага хурал нь дэлхийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулагдаж өнгөрсний дараа дараагийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах улсад болдог байна.

Хурлаар Олон улсын гал сөнөөгч, аврагчдын спортын холбооны үйл ажиллагаа, олон улсын хамтын ажиллагаа, Гал түймэр унтраах, аврагчдын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах, дараагийн онд хэрэгжүүлэх зорилт, асуудлын талаар хэлэлцдэг.

Чуулганд гал сөнөөгч, аврагчдын Олон улсын спортын холбооны гишүүд, улс орнуудын гал түймэр унтраах, аврах алба, яам, газар, холбоо, холбоодын дарга нар оролцдог. Улс бүр хоёр албан ёсны төлөөлөгчөөр төлөөлөх эрхтэй байдаг байна.

Олон улсын гал сөнөөгч, аврагчдын спортын холбооны гишүүн орнуудын Гал түймэр унтраах, аврах албаны дарга нарын олон улсын XXIII бага хурал нь 2022 онд Бүгд найрамдах Турк улсын Истанбул хотод зохион байгуулагдаж байсан бол XXIV бага хурал Бүгд найрамдах Хятад ард улсын Харбин хотноо энэ оны аравдугаар сарын 26-28-ны өдрүүдэд зохион байгуулна.

Тус холбоо байгуулагдсан цагаасаа эхлэн дүрэмд заасан зорилго, зорилтын дагуу үүсгэн байгуулагч орнуудын үндэсний холбоодын идэвхтэй оролцоотойгоор гал сөнөөгч, аврагчийн спортыг хөгжүүлэх, өргөн дэлгэр сурталчлах ажлыг хийж байна.

2002 оноос хойш Холбооны ивээл дор ХБНГУ, ОХУ, Солонгос, Чех, Турк, Болгар, Казахстан болон бусад хэд хэдэн оронд Дэлхийн аварга 15, Европын аварга гурав, Азийн цомын тэмцээн хоёр удаа зохион байгуулсан.

Түүнчлэн 2010 оноос хойш залуучууд, залуучуудын УАШТ-ийг жил бүр зохион байгуулдаг болсон.

2014 онд болсон түүхэн үйл явдал бол гал түймэр унтраах, аврах спортын төрөлд эмэгтэй баг тамирчид оролцсон явдал байв.

Манай улсын баг тамирчид 1973 онд Болгар улсад болсон социалист орнуудын нөхөрлөлийн тэмцээнд анх оролцсоноос хойш тасралтгүй 50 жил, 18 удаагийн тэмцээнд амжилттай оролцож, 2017 онд Бүгд найрамдах Турк улсын Измир хотод зохион байгуулагдсан Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс "Байлдааны тархалтын төрөл"-д багаараа хүрэл медаль хүртэн түүхэн амжилтыг үзүүлсэн билээ.

Холбооны дэмжлэгтэйгээр олон улсын тэмцээнүүдийг бусад улсын байгууллагууд зохион байгуулдаг.

Спортын арга хэмжээний хүрээнд дэлхийн тэргүүлэгч улс орнууд, үйлдвэрлэгчдийн галын техникийн бүтээгдэхүүн, аврах хэрэгслийн үзэсгэлэн, түүнчлэн гал сөнөөгч, аврагчдын спортыг хөгжүүлэх олон улсын хурал, олон улсын гал сөнөөгч, аврах албаны дарга нар оролцдог. Тус холбооноос Спортын техникийн хороо, Допингийн эсрэг сахилгын хороо, Спортын сахилгын хороог байгуулжээ.

Гал түймэр, аврах спортын "Олон улсын шүүгч" мэргэшлийн зэрэгтэй 70 гаруй хүн байгаа бөгөөд Монгол Улсаас Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын дарга, хурандаа Ц.Нямбаяр, олон улсын шүүгчээр ажилладаг байна.

Гал түймэр унтраах, аврах спортыг зөвхөн хүч чадал дээр суурилдаггүй бөгөөд хурд, бас багийн хамтын ажиллагаа, нөхөрлөл дээр суурилдаг бөгөөд энэ спортод улам олон хүн, спорт сонирхогчид хандах хандлагатай байгаа гэдэг утгаараа ирээдүйн спорт эсвэл их ирээдүйтэй спорт гэж тодорхойлж болно.

Гал түймэр унтраах, аврах спорт нь ямар ч насны хүмүүсийг байлдан дагуулж чаддаг. Тэмцлийн эрч хүч, үзвэрийн сонирхолтой байдал, тамирчдын эр зориг, мэргэжлийн ур чадварыг агуулсан байдаг.

Олон улсын хэмжээнд гал түймэр, аврах спортын хөгжил дэвшил нь зөвхөн олимпын хэтийн төлөвийг тодорхойлж байна.

## МОНГОЛ УЛСААС ДЭЛХИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД ОРОЛЦСОН БАЙДАЛ

**1973-1986 он** 1973 он Болгар, 1975 он Герман, 1977 он Чехословак, 1979 он ЗХУ-ын Сочи хот, 1981 он Унгар, 1984 он ЗХУ-ын Минск хот, 1986 он Польш улсад болсон Гал унтраах техникийн олон төрөлт спортын олон улсын уралдаан тэмцээнд Монгол Улсын шигшээ багийн тамирчид амжилттай оролцсон.



**1990-2000 он** ОХУ-ын Чита муж, Иркутск, Владивосток, Братск, Красноярск, Улан-Үдэ хотод зохион байгуулсан гал унтраах техник спортын Азийн болон олон улсын нээлтэй тэмцээнд давхардсан тоогоор 65 тамирчин оролцсон.



**2002 он** ОХУ-ын Москва хотод Олон улсын гал сөнөөгч, аврагчдын спортын дэлхийн аварга шалгаруулах анхдугаар тэмцээнд Монгол Улсын шигшээ багийн 12 тамирчид амжилттай оролцсон.

**2003 он** ОХУ-ын Владивосток хотноо болсон Азийн II удаагийн аварга шалгаруулах тэмцээнд шигшээ багийн тамирчид оролцож 4x100 метрийн буухиа тэмцээнд III байр эзэлж хүрэл медаль хүртсэн.

**2004 он** Беларусь улсын Минск хотод зохион байгуулагдсан Гал сөнөөгч, аврагчдын спортын дэлхийн II удаагийн аварга шалгаруулах тэмцээнд Монгол Улсын шигшээ багийн 14 тамирчид амжилттай оролцсон.

**2010 он** Солонгос улсын Дегу хотод болсон Дэлхийн гал сөнөөгчдийн их наадамд 26 тамирчин оролцсон.

**2012 он** Австралид болсон "Дэлхийн гал сөнөөгчдийн 12 дугаар их наадам"-д нийслэлийн Онцгой байдлын газрын орлогч дарга, онцгой байдлын хурандаа Д.Эрдэнэбаатар оролцсон.

**2013 он** Солонгос улсын Жинжу хотод зохион байгуулагдсан Олон улсын гал сөнөөгч, аврагчдын спортын Дэлхийн IX удаагийн аварга шалгаруулах тэмцээнд 12 тамирчин оролцсон.

**2014 он** Казакстан улсын Алма-Атад болсон Олон улсын гал сөнөөгч, аврагчдын спортын Дэлхийн X удаагийн аварга шалгаруулах тэмцээнд 11 тамирчин оролцсон.

**2015 он** ОХУ-ын Санкт-Петербург хотод зохион байгуулагдсан Олон улсын гал сөнөөгч, аврагчдын спортын Дэлхийн XI удаагийн аварга шалгаруулах тэмцээнд 10 тамирчин оролцсон.

**2017 он** Бүгд найрамдах Турк улсын Измир хотод зохион байгуулагдсан Олон улсын гал сөнөөгч, аврагчдын спортын Дэлхийн XIII удаагийн аварга шалгаруулах тэмцээнд есөн тамирчин оролцож байлдааны тархалтын тэмцээнд 27.08 секундын амжилт үзүүлж гуравдугаар байр эзлэн хүрэл медаль хүртсэн.



**2018 он** Бүгд найрамдах Словак улсын Банска Бистрица хотод зохион байгуулагдсан Олон улсын гал сөнөөгч, аврагчдын спортын Дэлхийн XIV удаагийн аварга шалгаруулах тэмцээнд 10 тамирчин оролцсон.

**2019 он** Оросын холбооны улсын Саратов хотод зохион байгуулагдсан Олон улсын гал сөнөөгч, аврагчдын спортын Дэлхийн XV удаагийн аварга шалгаруулах тэмцээнд есөн тамирчин оролцсон.

**2021 он** Казакстан улсын Караганда хотод зохион байгуулсан Олон улсын гал сөнөөгч, аврагчдын спортын Дэлхийн XVI удаагийн аварга шалгаруулах тэмцээнд 10 тамирчин оролцсон.

**2022 он** Бүгд найрамдах Узбекистан улсын Самарканд хотод зохион байгуулагдсан дэлхийн аварга, гал сөнөөгчдийн 17 дахь удаагийн насанд хүрэгчдийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд есөн тамирчин оролцсон.

**2023 он** Бүгд найрамдах Турк улсын Истанбул хотод зохион байгуулагдсан дэлхийн аварга, гал сөнөөгчдийн 18 дахь удаагийн насанд хүрэгчдийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд 12 тамирчин оролцсон.

# АЗ ЖАРГАЛ БЭЛЭТГЛЭТЧИД



**“Аюул нөхцөл байдлаас хүний амийг аварч бусдад их тус хүргэдэг гэдэг утгаараа гал сөнөөгчдийн 80 хувь нь өөрсдийн хийж буй ажилдаа сэтгэл хангалуун байдаг” гэсэн дүгнэлтийг Чикагогийн их сургуулиас хийсэн нийгмийн суурь судалгаа харуулжээ. Олонх нь бухимдалд автсан энэ нийгэмд аз жаргалаар бялхаж гэр бүлээрээ бусдад аз жаргал бэлэглэдэг гэх бахархалтайгаар амьдрах нь юутай сайхан бэ. Ажилдаа гарцаагүй сэтгэл хангалуун нь илэрхий, гал сөнөөгч Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Гал унтраах аврах Х ангийн салаан захирагчийн туслах ахлах ахлагч Д.Ганзоригтой ярилцлаа. Түүний яриа бүхэлдээ өөдрөг үзэл, бахархал омогшлоор бялхаж байсан нь ажлаасаа халшрах, хойш суух хам шинжид өртсөн сэтгүүлч надад ч урам зориг, аз жаргалтайгаар ажиллаж чадах итгэлийг өгсөн юм.**



-Баянхонгор аймгийн Баян-Овоо суманд төрсөн. Аав маань Архангай аймгийн харьяат. Гэхдээ Дарханд ирж суурьшсан учраас дунд сургуулиа би Дарханд төгссөн. Сургуулиа төгсөөд Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд цэргийн алба хаасан. Тэр үед манай хоёр ах Дархан-Уул аймгийн гал унтраах 22 дугаар ангид ажилладаг байлаа. Том ах жолоочоор, харин яг миний дээд талын ах гал сөнөөгч. Бас нэг найз маань ч тус 22 дугаар ангид гал сөнөөгчөөр ажилладаг байсан юм. Намайг цэргээс халагдахад буюу 2002 онд Дарханаас Улаанбаатарт шилжин ирж Чингэлтэй дүүргийн Гал унтраах одоо миний ажиллаж байгаа энэ ангид гал сөнөөгчөөр ирсэн байлаа. Би ч цэргээс халагдаад хотод ирж, найзтайгаа уулзахаар ажил дээр нь их очино. Тэр үед хонх дугаараад найз маань галын дуудлагаар явна. Дуут дохиогоо хангинуулсан улаан машинд суугаад гарахад нь их бахархдаг байв. Тэгж яваад л энд ажилд орсон доо. Бараг 20 жил яг энэ ангидаа бууриа сахиж, тогтвор суурьшилтай ажиллажээ.

-Эхнэрийг маань Ц.Өсөхжаргал гэдэг. “Өргөө” амаржих газар эх баригчаар ажилладаг. Хотод гал сөнөөгчийн ажилд ороод ээлжийн амралтаараа Дарханд гэртээ харих үедээ анх танилцсан. Эхнэр маань Увсынх, тухайн үед Дарханы анагаахын сургуулийн оюутан байв. Сургуулиа төгсөхөд нь Улаанбаатарт суурьшиж гал голомтоо бадраасан даа. Эхнэр хорвоод мэндэлж байгаа нялх үрсийг эх барьж, би хүний амь нас, эд хөрөнгө авардаг буянтай сайхан мэргэжилтэй. Гэр бүлээрээ айл гэрт аз жаргал бэлэглэдэг гэдэгтээ маш их бахархаж явдаг. Манайх 14,9, 5 насны гурван хүүхэдтэй. Байгууллага маань ажилчдынхаа нийгмийн асуудалд анхаарч түрээслээд өмчлөх хэлбэрээр орон сууцжуулсан. Манайх хамрагдаж орон сууцтай болоод дөрвөн жил өнгөрчээ.

-Анхны галын дуудлага, Баянбүрдийн гэр хороололд айлын байшин шатаж байхад очиж байв. Шинэ гал сөнөөгчийн хувьд их сүрдмээр юм билээ. Гэхдээ дадлага сургуулилт, ах нарын заавар, багийнхантайгаа хамтран амжилттай унтраасан. Тэр үеэс хойш 2000 гаруй дуудлагад гарч 1000 орчим хүнийг утаажилтын бүсээс гаргажээ. 2012 онд Баянгол дүүргийн арктай шар байрны үзелийн өрөөнд шөнийн цагаар амарч байхдаа угаартаж ухаан алдсан сантехникийн ажилтны амийг аварсан юм. Тухайн үед хаалга нь цоожтой, жижигхэн салхивчаар нь амьсгалын бие даасан төхөөрөмжтэй орсон. Тэгээд “Онц гал сөнөөгч” тэмдгээр шагнуулж байлаа. Ер нь хүмүүсээс баярлалаа гэдэг үгийг их сонсдог. “Хурдан ирж амь нас эд хөрөнгийг минь хамгаалж өгсөн” гээд утсаар, бичгээр байгууллагад маань талархал их ирүүлдэг.

Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Гал унтраах аврах Х ангийн хувьд нийслэлийн хэмжээнд гал түймрийн дуудлага 50-70 хувьд явдаг онцлогтой. Зөвхөн Чингэлтэй гэхгүй III, IV хороолол, Гэмтлийн эмнэлэг, Зурагтаас гадна бүх дүүрэгт хүч нэмж нэмэлтээр гарна. Манай анги гал унтраах, аврах гурван тасагтай. Миний хувьд хоёрдугаар тасгийг удирдан авч гардаг. Манай тасаг даргаас гадна, жолооч, дөрвөн гал сөнөөгч, холбоочин гээд зургуул.

-Цаг агаар, орчны нөхцөл байдлаас хамаарч гал хаашаа ч эргэж болдог. Барилга объектийн онцлогоос хамаарч хаана ямар ч хүндрэл үүсч магадгүй. Тиймээс гал сөнөөгч хүн түргэн сэтгэх, нөхцөл байдалдаа тохирсон шийдвэрийг хурдан гаргах шаардлага тулгардаг. Тиймээс авхаалж самбаа хурдтай байх ёстой. Мөн баг ахлаж яваа хүн, хэн нь хаана юу хийж байгааг мэдэрч ажилладаг байх чухал. Гал дээр очихоос өмнө утааг нь хараад дүгнэлтээ өгдөг. Нэлээд дэлгэрсэн гал байвал очихоосоо өмнө нэмэлт хүч авах гэх мэтээр замдаа шийдвэрээ гаргаж явдаг.

-Би ер нь гал сөнөөгч болоогүй бол хаана юу хийгээд явж байгаа төсөөлдөггүй. Энэ байгууллагад орсондоо үргэлж бахархаж явдаг. Анги маань миний хоёр дахь гэр. Хамт олон минь ч хамаатан садангаас өөрцгүй шүү дээ. Жаргал зовлонгоо ярина. Хоол ундаа хувааж иднэ. Амралтаа аваад сайн бол долоо хоноод л ажлаа санаж эхэлнэ. Гадуур



дохио дуугаргаад давхиж яваа машинаа хараад гэгэлзэнэ. Уг нь тэтгэвэрт гарах болзол дөхөж байгаа. Гэхдээ тэтгэвэрт гарах бодол алга. Офицер болно. Би сая Дотоод хэргийн их сургуулийн таван жилийн эцнээ ангийг гамшгаас хамгаалах мэргэжлээр төгссөн. Сургуульд сурсаныхаа үр шимийг гаргана. Өмнө нь практик дээр мэдлэг олж авсан. Сая онол сурлаа. Их сургуульд элсээгүй байхдаа юмыг хар ухаанаар л боддог байсан юм байна лээ. Онол практик хоёрыг хослуулна гэдэг их өөр юм. Харьцуулах юм ч их гарна.

-2021 онд өмнөд Суданд үүрэг гүйцэтгэсэн нь бас нэг их сургууль болсон. Очоод буу зэвсэгтэй харьцахаас эхлээд бүх юмыг анхнаас нь сурсан. Өмнө нь хэзээ ч төсөөлж ч байгаагүй газар очиж үзлээ. Улаан шороо эргэлдсэн, намхан өвстэй маш халуун. Хөөрхий нутгийн хүмүүс хоол нэхнэ. Хүүхдүүд нь монголоор ярина, ганц чихэр ч болтугай өгөхийг хичээдэг байлаа. Тэнд борооны болон халууны гэсэн хоёрхон улиралтай. Хүүхдүүд борооны тогтоол усанд сэлнэ, хувцсаа угаана. Харахад сэтгэл шимширдэг байлаа. Тэр хүмүүсийг хараад “Монголд төрсөн бид азтай хүмүүс шүү” гэж өөрийн эрхгүй бодогддог юм билээ. Монгол сайхан, ийм сайхан эх оронтойдоо бахархаж омогшихоос аргагүй.

-Галын байгууллагад шинээр орж ирсэн залуустаа халамжлан хүмүүжүүлэгч томилж өөрийгөө болон бусдыг аврах арга ухааныг бугдгийг нь зааж сургадаг. Сэтгэл зүрхээ зориулаад тууштай ажиллахаар зориг шулуудан орж ирсэн сайхан залуус олон. Мэдээж хүн болсон хойно шантардаг, гадагшаа явах боллоо. Ажлаасаа гарлаа гэх нь ч бий. Уг нь хүний төрөлх нутаг, эх орон гэдэг сайхан. Гэр орон хайртай хүмүүстэйгээ хамт байхаас өөр аз жаргал юу байх вэ.

Дээр нь төрийн байгууллагад ажиллах нь нийгмийн баталгаа болчихож байна. Тиймээс харь оронд явахаасаа өмнө жаахан хүлээцтэй тэвчээртэй хэдэн жил ажиллаад үзээсэй гэж бодож, зөвлөдөг. Бас залуу нас, эр зоригийн энэ албанд орж ажиллаарай гэж уриалж байна. Алба хаагчдын цалин, нийгмийн баталгаа, хангамж маш сайн болсон. Өмнө нь бид нэг хувцас, хэрэгслийг хүлээлцэж, ээлжилж хэрэглэдэг байв. Одоо бол өвөл зуны, усны хувцас хамгаалах хэрэгслийг хүн нэг бүрт олгодог болсон. Дээр үеийн орос машин битүүмжлэл муутай өвөл хүйтэн, зун халуун. Одоогийн машин техник тохилог дулаан, үүргээ гүйцэтгээд буцахад даарч хөрнө гэж байхгүй. Нэмээд цэргийн байгууллага, албаны онцлогоос шалтгаалаад алба хаагчид маш сайн төлөвшил, хүн ёсны боловсролтой болдог онцлогтой алба даа.

-Гал унтраах техникийн олон төрөлт спортоор хичээллэдэг. Байлдааны тархалт, 4x4, довтлоого, саадтай 100, гурав сунадаг зэрэг таван төрлөөр тэмцээн болдог байсан юм. Сүүлд дөрвөн төрөл болсон. 2013 онд БНСУ-д болсон Дэлхийн аваргын тэмцээнд Монгол Улсаа төлөөлөн баг тамирчидтайгаа орон нутгаас шалгарч оролцсон. 2014 онд Алматы хотод болсон тэмцээнд амжилттай оролцож олон улсын мастерын болзол хангаж байв. 2016 онд Булган аймагт болсон гал унтраах техникийн олон төрөлт спортын 60 жилийн ойн тэмцээний үеэр зодог тайлсан. Энэ тэмцээн гал сөнөөгчдийн мэргэжлийн тэмцээн. Гал унтраах ангийнхны яг суурь нь болдог. Гал түймэр унтраах явцдаа гал сөнөөгчдийн хийдэг хоолой шланг дэлгэх, шаттай харьцах, байлдааны тархалт хийх зэргээр явагддаг юм. Хурд нь секунд долиор хэмжигдэнэ. 2023 оны гал унтраах олон техникийн олон төрөлт тэмцээний Дэлхийн аварга шалгаруулах 18 дахь удаагийн тэмцээн хэдхэн хоногийн өмнө Турк улсын Станбул хотод болж, Гамшиг судлалын хүрээлэнгийн Аюулгүй байдлын нэгдсэн үнэлгээний төвийн дарга, хошууч Э.Энхбат бид хоёр дасгалжуулагчаар явсан. 4x100 метр төрөлд Монгол Улсынхаа рекордыг шинээр тогтоож, 57.77 болгож ирсэн. Энэ нь 100 метрт 57 секунд 77 доль хугацаанд гүйсэн гэсэн үг. Зүгээр гүйчихгүй шүү дээ, зам бүр дээр өөр өөр төрлөөр өрсөлдөөд хамгийн сүүлд гал унтраах хороор тэвштэй гал унтраагаад баринд орж ирдэг. Энэ төрөлд ОХУ-ын тамирчид ер нь тэргүүлсээр байгаа. Тэд бол жилийн турш заалны бэлтгэл хийж хүүхдүүдийг багаас нь энэ спортоор хичээллүүлж тэднээсээ сонгон шалгаруулж авч байна. Манайх улс, бүсийн аварга шалгаруулах тэмцээн жилд нэг болоод тэднээсээ сонгоод дэлхийн аваргад ордог. Яг одоо ажиллаж байгаа алба хаагчдаасаа шигшиж оролцуулдаг. Жинхэнэ залуу насны, хурд хүч шаарддаг тэмцээн учраас зодог тайлсан. Одоо бол сагс сонирхоно. Гэхдээ энэ байгууллагад орсноосоо хойш хөл бөмбөг, волейбол гээд бүх төрлийн тэмцээнд оролцсон доо. Спортоос гадна төрөл бүрийн эмблем цуглуулдаг. Энд тэнд очсон явсан газраасаа цуглуулна. Бас хүмүүстэй солилцоно.

-Бидний ажлын үндсэн чиг үүрэг бол хүний амь нас, эд хөрөнгийг авран хамгаалах л юм шүү дээ. Авран хамгаалахаас илүү урьдчилан сэргийлэх учиртай. Тиймээс бид урьдчилан сэргийлэх ажлыг сар, улирал бүр хийж байна. Сургалт сурталчилгаа хийнэ. Ярина, ойлгуулна. Өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндээ ингэж хамгаалаарай гэхэд хүмүүсийн хүлээж авах чадвар, ухамсар сайн болсонд тун баяртай явдаг.





**2014.07.14**

Сүхбаатар дүүргийн IV хорооны нутаг дэвсгэрт байршилтай I Дөчин мянгатын 40, 42, 44 дүгээр байранд 2014 оны долдугаар сарын 14-ний өдрийн 15:08 минутад гал түймэр гарсан. Түймрийг нийслэлийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах найман ангийн нийт нийт тасаг, гал унтраах зориулалтын 17 автомашин, 71 албан хаагч, 3 цаг 31 минут ажиллаж бүрэн унтраасан. Ингэхдээ 160.5 тонн ус, 669.5 литр шатахуун зарцуулж, хорт хий утаанаас хамгаалах 58 ширхэг багтай ажиллажээ.



**2014.09.30**

Сүхбаатар дүүргийн I хороо Олимпын гудамжид байрлах "Шангрила" зочид буудлыг барьж байх явцад буюу барилгын ажил 80 хувийн гүйцэтгэлтэй байхад 2014 оны есдүгээр сарын 30-ны өдрийн 12:49 цагт түймэр гарсан. Гурван ангийн дөрвөн тасгийн нийт 52 алба хаагч, есөн автомашин, техниктэйгээр галыг унтраасан. 34 тонн ус, 272.91 литр шатахуун зарцуулан дөрвөн цаг 40 минутын турш ажиллаж бүрэн унтраасан байна.

## УЛСЫН ХЭМЖЭЭНД ТОХИОЛДСОН ОБЪЕКТЫН ТОМООХОН ГАЛ ТҮЙМРҮҮД

**2013.08.23**

2013 оны наймдугаар сарны 23-ны өдрийн 06 цаг 20 минутад нийслэлийн Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн 101 дугаарын утсанд нийслэлийн Баянзүрх дүүрэг Нарантуул захын баруун талд байшин шатаж байна гэж нэрээ хэлээгүй иргэн утсаар дуудлага өгсөн байна. Тус төвийн ахлах зохицуулагч онцгой байдлын хошууч Д.Оюунбат үйлчлэх хүрээний Гал түймэр унтраах, аврах 63 дугаар ангийн тасгийг 06:22 цагт гаргасан. Ойр орчмын хяналтын дэлгэцээр нөхцөл байдлыг татаж харахад их хэмжээний өтгөн хар утаа, галын дөл гарч байсан бөгөөд гал түймрийн тухай дуудлага тасралтгүй ирж байсан тул нэмэлтээр Гал түймэр унтраах, аврах ангиудыг гаргасан. Анхны дуудлагаар очсон гал унтраах удирдагч Нарантуул олон улсын худалдааны төвийн хүнсний захад гал түймэр гарч байгаа болохыг мэдэгдсэнээр хүч хэрэгслийг төвлөрүүлж эхэлжээ.

Тус худалдааны төвийн хүнсний захын барилга нь 1999 онд баригдсан зоорины давхартайгаа гурван давхар төмөр бетон каркас тулгуур баганатай, багана хооронд шивлээр холбоотой, дээврийн хийц гурван хэсэг дээвэр хагас нуман хэлбэрийн төмөр хийцтэй. Хөөсөнцрөөр дулаалж, тороосоор татаж бэхэлсэн, ханын өрлөг нь хөнгөн блок, гадна талаараа сэндвич ханатай. Тэнхлэгээрээ урт нь 127 м, өргөн 69 м, хойд, урд, баруун, зүүн талдаа дөрвөн авралтын гарцтай. Уг барилгын хоёрдугаар давхарт 19 аж ахуйн нэгж үсчин, оёдолчин, ломбардын чиглэлээр, I давхарт цайны газар, хүнс, гоо сайхны худалдааны 98, зоорины давхарт хүнс, гоо сайхны барааны 40 агуулах нийт 350 түрээслэгч үйл ажиллагаа явуулдаг байжээ.

Тус гал түймрийг унтраахад нийслэлийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах аврах зурган ангийн найман тасаг нийт 141 албан хаагчид 494 тонн ус, 1848 литр шатахуун зарцуулж галыг бүрэн унтраасан бөгөөд уг гал түймрийн хор уршгийг арилгах ажилд нийслэлийн аврах анги, Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн алба хаагчид долоо хоног ажилласан байна.

**2014.05.10**

Баянгол дүүргийн XX хорооны нутаг дэвсгэрт байршилтай МВС групп компанийн "Барс-2" худалдааны төвийн цайны газарт хийн түлш / газ / дэлбэрсэн гэсэн дуудлага нийслэлийн Мэдээлэл шуурхай удирдлагын төвд 2014 оны тавдугаар сарын 10-ны өдрийн 10:47 цагт ирсэн байна. Гал түймэрт худалдааны төвийн урд хэсэгт байрлах 30x10 метрийн хэмжээтэй сэндвичэн өргөтгөлийн цайны газрын дөрвөн хоол бэлтгэх өрөө, дээвэр, хана, тааз, дотор эд хогшил, долоон ширхэг хийн түлшний сав, зэргэлдээ павильоны дээвэр, хана шатсан байна. Нийслэлийн Онцгой байдлын газрын 68 албан хаагч, 13 автомашинтай 29 тонн ус, 327.99 литр шатахуун зарцуулан 2 цаг 30 минут ажиллаж унтрааж тухайн байгууллагын гурван павильон бүхий худалдаа үйлчилгээний төв, ногооны агуулах, худалдааны танхим, контор, өргөтгөл 30x60 метр хэмжээтэй хоёр давхар тоосгон, сэндвичэн павильоныг гал түймрийн аюулаас авран хамгаалсан.



**2015.02.04**

Сүхбаатар дүүргийн VI хороо, Хаан гэр ресторанд 2015 оны хоёрдугаар сарын 4-ны өдрийн 15 цаг 33 минутад гал түймэр гарсан. Түймрийг нийслэлийн Гал түймэр унтраах аврах долоон анги, найман тасгийн 120 албан хаагч, 20 техник хэрэгслийг гал унтраах дөрвөн хэсэгт хувааж гал унтраах үйл ажиллагааг явуулсны үр дүнд 20:30 цагт гал түймрийн тархалтыг зогсоов. 01:49 цагт буюу 10 цаг 16 минут 203.5 тонн ус, 1959.83 литр шатахуун зарцуулж гал түймрийг бүрэн унтраасан байна.

**2017.02.07**

Баянзүрх дүүргийн XII хороо, Ботаникийн эцэст байрлах "Бишрэлт трейд" компанийн 46x24 метрийн хэмжээтэй "Велл март" худалдааны төвийн II давхарт 2017 оны хоёрдугаар сарын 7-ны өдрийн 02 цаг 50 минутад гарсан гал түймрийг нийслэлийн Онцгой байдлын газрын дөрвөн ангийн долоон тасаг, гал унтраах зориулалтын 11 автомашин, 75 албан хаагч, 6 цаг 23 минут ажиллаж 53.5 тонн ус, 857.9 литр шатахуун зарцуулж, хорт хий утаанаас хамгаалах 52 багтай ажиллаж унтрааж тус объектын нэг болон гурван давхарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн өмч хөрөнгийг авран хамгаалсан байна.



**2017.06.14**

Хан-Уул дүүргийн III хороо "Говь" үйлдвэрийн барилгад 2017 оны зургаадугаар сарны 14-ний өдрийн 20 цаг 39 минутад гал түймэр гаргасан.

Үйлдвэрийн зориулалттай тус байгууламж нь 1981 онд баригдсан хоёр давхар төмөр бетон хана, тулгуур баганатай, тэнхлэгээрээ урт нь 198 м, өргөн нь 126м дээврийн хэсэг нь төмөр бетонон дээвэртэй, дээгүүр нь 30 см орчим зузаантай шилэн хөвөн, хөөсөнцрөөр дулаалж, модоор давхарлан, 6-7 давхар хар цаасан хучлагатай байсан нь гал тархан дэлгэрэх болон шаталга эрчимтэй явагдаж, унтраах үйл ажиллагаанд хүндрэл учирч байсан.

Уг гал түймрийг унтраахад Онцгой байдлын байгууллагаас 241 алба хаагч, 34 автомашин, бусад байгууллагаас 102 алба хаагч ажилтан, 68 автомашин, техниктэйгээр 21 цаг үүрэг гүйцэтгэж, ус 2396 тн, хөөс үүсгэгч 1100 л, шатахуун 7716 литрийг зарцуулан бүрэн унтраасан байна.

Гал түймэр унтраах автомашиныг сэлгэн байрлуулах боломж хязгаарлагдмал, гал хурдан тархах материал болох хөөсөнцөр, хар цаасаар галын тархалт маш эрчимтэй явагдсан, галын ачаалал их, олон давхарлагдаж зузаарсан. Хар цаасанд задаргаа хийхэд хүндрэлтэй, нягт ихтэй, хорт хий, утаа их хэмжээгээр ялгарсан зэрэг нь гал унтраах үйл ажиллагааг хүндрүүлж байв. Гал унтраах үйл ажиллагааг зохион байгуулахад тус объектын 30 мянган ам.метр том талбай өртөж, гал түймрийн шаталт маш эрчимтэй явагдсан. Дулааны үйлчлэл өндөр, далд шаталт ихтэй, хавь шатсан зэргээс усны шаардлага нэмэгдэж байсан тул Ус сувгийн удирдах газраас таван тн багтаамжтай ус тээвэрлэгч 11, Хот тохижилтын газраас долоон тн багтаамжтай ус тээвэрлэгч зургааг, Улаанбаатар төмөр замаас 68 тн усны савтай вагонцистерн зэргийг хүч нэмэгдүүлэн ажиллажээ.






**2020.05.22**

2020 оны тавдугаар сарын 22-ны өдрийн 14 цаг 45 минутад Сонгинохайрхан дүүргийн XX хороо Толгойт найрамдлын замын 59 тоотод "Ондилт" компанийн дээврийн ус тусгаарлах барилгын материал зардаг аж ахуйн хашаанд гал гарсан. Гал түймрийг нийслэлийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах аврах таван ангийн таван тасгийн нийт 52 алба хаагч, 15 автомашинтайгаар таван цаг ажиллаж 220.5 тонн ус, 904.15 литр шатахуун зарцуулан унтраав.

**2020.06.07**

Чингэлтэй дүүргийн III хороо Энхтайваны өргөн чөлөө "Номин Холдинг" компанийн Улсын их дэлгүүрт 2020 оны зургаадугаар сарын 7-ны өдрийн 16 цаг 48 минутад гарсан гал түймрийг нийслэлийн хүрээний Гал түймэр унтраах, аврах долоон анги, аврах ангийн нийт 230 алба хаагч, 27 автомашинтайгаар 40 минут ажиллаж гал түймрийн тархалтыг зогсоож, 4 цаг 40 минут ажиллаж 343 тн ус, 1895.73 литр шатахуун зарцуулж унтраасан. Мөн гал түймрийг унтраахад нийт дөрвөн байгууллагын 197 ажилтан, алба хаагч, 24 автомашин, техник хэрэгсэлтэйгээр хамтран ажилласан байна. Уг гал түймрээс долоон иргэний амь нас, нэгээс тавдугаар давхарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, иргэдийн эд хөрөнгийг авран хамгаалсан. Нэмж дурдахад "Номин Холдинг" ХХК-ний Улсын их дэлгүүр нь 1961 онд баригдсан, 59 жилийн насжилттай хуучны зургаан давхар барилга бөгөөд 64 см-ын тоосгон ханатай, долоон давхрын өргөтгөл нь төмөр каркас, блокоор баригдсан, сэндвичэн дээвэртэй, модон цонхтой бөгөөд барилгын урт нь 78 метр, өргөн нь 60 метр, дотуур усан хангамжтай, авралтын долоон гарцтай, нийт 23.6 мянган м/кв талбайд үйл ажиллагаа явуулдаг. Тус дэлгүүр нь 80 орчим тасаг 500 гаруй ажилтан, харилцагчийн 50 тасагт 220, түрээслэгчийн 130 тасагт 260 нийт 1000 гаруй ажилтантай, өдөрт ойролцоогоор 15-20 мянган хүн үйлчлүүлдэг худалдааны байгууламж юм.




**2022.01.06**

2022 оны нэгдүгээр сарын 6-ны өдрийн 05:04 цагт Сонгинохайрхан дүүргийн XX хороо "Таван толгой" компанийн баруун түүгээ төвийн хашаанд сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн хатаалгын 60x12 метрийн хэмжээтэй барилгын II, III шугам, 50x100 метрийн хэмжээтэй үйлдвэрийн I цех, савлагааны цехэд гарсан гал түймрийг нийслэлийн Онцгой байдлын газрын таван ангийн 19 автомашин, 56 алба хаагч 5 цаг 23 минут ажиллаж унтрааж байв.



**2022.12.01**

Дархан-Уул аймгийн Дархан сумын III багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг "Тэс Петролиум" компанийн газрын тосны бүтээгдэхүүн хадгалах агуулахад дэлбэрэлт болж, гал түймэр гарсан тухай дуудлагыг 2022 оны арванхоёрдугаар сарын 1-ний өдрийн 09:21 цагт Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газар хүлээж авсан. Дээрх дуудлагын дагуу Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын гал түймэр унтраах, аврах анги 22, 54 дүгээр анги, Эрэн хайх аврах бүлэг, Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын гал түймэр унтраах, аврах 19, 36, 40, 61 дүгээр анги, Орхон аймгийн Онцгой байдлын газрын гал түймэр унтраах, аврах 56 дугаар анги тус тус голомтод үүрэг гүйцэтгэжээ.



Уг газрын тосны бүтээгдэхүүн хадгалах агуулахын гал түймэрт өртсөн сав, саванд байгаа шатахууны хэмжээ, далангийн хэмжээ, шаардлагатай хөөс үүсгэгч бодис, усны нөөцийн хэмжээнд тооцоолол хийж үзэхэд 14580 литр хөөс үүсгэгч бодис, 243 мянган литр ус шаардлагатай байсан. Тиймээс нийслэлийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 10, 26, 63 дугаар ангийн тус бүр нь таван тонн хөөс үүсгэгч бодис бүхий хөөсөөр гал түймэр унтраах зориулалтын гурван автомашин 11 албан хаагч нэмэлтээр үүрэг гүйцэтгэсэн.

Нийслэлийн Онцгой байдлын газраас гарсан хөөсөөр гал түймэр унтраах зориулалт бүхий автомашинууд болон нэмэлтээр гарсан ус тээвэрлэх зориулалттай галт тэрэг, автомашины гал түймрийн голомтод очих хүртэлх хугацаанд гал түймэр унтраах, аврах долоон ангийн 15 автомашин, 129 албан хаагч зэргэлдээх тус бүр нь 400 м3-ийн багтаамжтай зургаан сав болон гал түймэрт өртсөн 2000 м3-ийн багтаамжтай савыг гал унтраах бодисоор тасралтгүй хөргөлт хийж, тухайн саван дахь шатахуун дэврэх, хальж асгарах, саванд задрал үүсэж, гал түймэр тархан дэлгэрэхээс урьдчилан сэргийлж ажилласан байна.

Гал түймрийг унтраах үйл ажиллагааг 9 цаг 17 минутын турш зохион байгуулж, нийт Гал түймэр унтраах, аврах 10 ангийн 140 алба хаагч, 20 автомашинтай ажилласан. 150 тонн ус, 2.7 тонн шатахуун, 18.2 тонн хөөс үүсгэгч бодис зарцуулан, 17:18 цагт гал түймрийн тархалтыг зогсоож, хайгуул, үзлэг шалгалт хийн, 18:44 цагт гал түймрийг бүрэн унтраасан. Гал түймэр унтраах, аврах ангиудын бэлтгэл, бэлэн байдлыг хангахаар урьдчилан сэргийлж чадсан байна. Мөн Дархан-Уул аймгийн Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Дархан-Уул сумын ЗДТГ, Дархан-Ус суваг, УБТЗ-ын Мандал сум дахь Цэрэгжүүлсэн хамгаалалтай Онцгой байдлын алба, "Дархан төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК зэрэг нийт найман аж ахуйн нэгж, байгууллагын 152 алба хаагч, 30 автомашин, нэг галт тэрэгтэй ажиллаж дэмжлэг үзүүлжээ.

## СОНИРХУУЛАХАД

**Онцгой байдлын байгууллага сүүлийн үеийн, олон улсын стандартын шаардлагыг хангасан, дэвшилтэт компьютерийн программ хангамж, тусгай тоноглолоор угсрагдсан автомашинуудыг ашиглаж байна. Энэ нь биднээс ажиллагааны зааврын материалтай нарийвчлан танилцах, техникийн шинэ эрин үеийн хандлага, ур чадварыг зайлшгүй шаарддаг билээ.**



## ЯПОН

Гал унтраах тусгай зориулалтын автомашин, унтраагуур, объектын гал түймрийн хамгаалалтын систем, робот, хог боловсруулах, зөөвөрлөх эко тоног төхөөрөмж үйлдвэрлэгч "Морита групп"-т үйлдвэрлэсэн автомашинуудыг Монгол Улсад ашиглаж байна.

Япон улсын "Морита групп" нь 1907 онд байгуулагдаж, одоог хүртэл автомашин, тоног төхөөрөмжийн сайжруулалтыг тасралтгүй хөгжүүлсээр ирсэн. Солонгос, БНХАУ, ОХУ, Хойд Америк,

Франц, Итали, Англи зэрэг оронд бүтээгдэхүүнээ нийлүүлдэг.

Манай улсад нийлүүлсэн автомашинууд нь -40+400°С хүртэлх агаарын хэмд үүрэг гүйцэтгэх боломжтой



Галын автоцистерн ISUZU FTS33HL /4x4/ 3.5 тонн ус, 300 литр химийн бодисын багтаамжтай, объектын гал түймэр унтраах багаж хэрэгслээр бүрэн тоноглогдсон.



Гал унтраах үндсэн албаны ISUZU CVZ51KLM /6x4/ найман тонн ус тээвэрлэгч автомашин, объектын гал түймэр унтраах багаж хэрэгслээр тоноглогдсон.



2013

2013



2013



2003



2013

Гал унтраах үндсэн албаны автомашин MITSUBISHI FV515M - 10 тн объектын гал түймэр унтраах багаж хэрэгслээр бүрэн тоноглогдсон. Бие бүрэлдэхүүн, гал унтраах техник, багаж зэвсэглэмжийг зөөвөрлөх, гал унтраах бодисын /ус, хөөс/ нөөцийг галын голомт руу өгөх.

Гал унтраах үндсэн албаны ISUZU CVZ51Q /6x4/ есөн тонн ус, нэг тонн химийн бодисын багтаамжтай объектын гал түймэр унтраах багаж хэрэгслээр бүрэн тоноглогдсон.

Гал унтраах автомеханик шат MITSUBISHI FV515P өндрөөс аврах ажиллагаа зохион байгуулах, гал унтраах зориулалттай тусгай механизмаар тоноглогдсон шатны автомашин юм.

Гэрэл, холбооны ISUZU FTS33N 4x4 – гэрэлтүүлэгч объектын гал түймэр унтраах үед харагдах орчин хязгаарлагдсан үед гэрэлтүүлэг, цахилгаан үүсгэгчээр тоноглогдсон тусгай албаны автомашин юм.

## БЕЛАРУСЬ

Гал унтраах тусгай зориулалтын болон ачаа, зорчиг, дугуйт тээвэрлэгч, жижиг оврын автобус, автомашин үйлдвэрлэгч "МАЗ"-т үйлдвэрлэгдсэн автомашинуудыг Монгол Улсын Засгийн Газар, Бүгд найрамдах Беларусь улсын Засгийн газар хоорондын экспортын зээлийн ерөнхий хэлэлцээрийн дагуу "Онцгой байдлын албаны гамшигтай тэмцэх техник тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах" төслийн хүрээнд хүлээн авч, ашиглаж байна.

Бүгд найрамдах Беларусь улсын Минск хотын "МАЗ" үйлдвэр нь Вьетнам, ОХУ, Казахстан, Зимбаб, Узбекистан, Молдов зэрэг орнуудад нийт 200 гаруй автомашиныг нийлүүлсэн. Монгол Улсад нийлүүлсэн автомашинууд нь тусгай захиалгаар үйлдвэрлэгдсэн бөгөөд гал унтраах үндсэн албаны болон тусгай зориулалтын багаж зэвсэглэмжээр тоноглогдсон, эрс тэс уур амьсгалтай орчны агаарын хэм нь -40+400С-т үүрэг гүйцэтгэх боломжтой.



Үйлдвэрлэсэн компани: "ПОЖНАБ" ХХК  
Автомашинны загвар: МАЗ АЦ 11.0-40 (6317)  
Хөдөлгүүрийн хүчин чадал кВт (морины хүч): 307 (417,5)  
-Гал унтраах хөөрөг /насос/-ний загвар: НЦПН-40/100  
-Гал унтраах хөөрөг /насос/-ний хүчин чадал: 40 л/сек  
-Усны савны хэмжээ: 11 мянган литр  
-Хөөс үүсгэгч бодисын савны хэмжээ: 660 литр  
-Суурин лафетны хушуу, хүчин чадал: ЛС-С40У  
0.4-0.8 мпа даралтад 40 л/с  
Агаар механикийн хөөсийг дамжуулах зай 40 м  
Тусгалын зай 300 – 60/40 м  
-Зургаан хувийн найрлага бүхий хөөс үүсгэгч бодисыг ГПС-600 генератораар нэгэн зэрэг дамжуулах хамгийн их боломж - таван ширхэг



Үйлдвэрлэсэн компани: "ПОЖНАБ" ХХК  
Автомашинны загвар: МАЗ АЦ 5.0-40 (5434)  
Хөдөлгүүрийн хүчин чадал кВт (морины хүч): 197,1 (268)  
-Гал унтраах хөөрөг /насос/-ний загвар: НЦПН-40/100-В1Т-(В1У)  
-Гал унтраах хөөрөг /насос/-ний хүчин чадал: 40 л/сек  
-Усны савны хэмжээ: 5000 литр  
-Хөөс үүсгэгч бодисын савны хэмжээ: 300 литр  
-Суурин лафетны хушуу, хүчин чадал: ЛС-С40У  
0.4-0.8 мпа даралтад 40 л/с



Үйлдвэрлэсэн компани: "ПОЖНАБ" ХХК  
Автомашинны загвар: АЛ-32 (5340) 4x2  
Хөдөлгүүрийн чадал, кВт (морины хүч), - 202  
Ажлын хамгийн их өндөр, м – 32  
Шатны хамгийн урт сунасан үеийн ажлын ачаалал кг, багагүй – 300  
Өндрөөс аврах ажиллагааг зохион байгуулах, объектын гал түймрийг унтраах шийдвэрлэх чиглэлд түргэн шуурхай ажиллана.

## ФРАНЦ

Гал унтраах тусгай зориулалтын болон том оврын тээврийн автомашин, унтраагуур, объектын гал түймрийн хамгаалалтын систем, төхөөрөмжийн дэвшилтэт үйлдвэрлэгч "Десотел групп"-т үйлдвэрлэсэн автомашинуудыг Монгол Улсын Засгийн газар, Бүгд найрамдах Франц улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн дагуу "Онцгой байдлын байгууллагад агаараас аврах ажиллагаа явуулах нэгж байгуулах, нисдэг тэрэг, гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх" төслөөр хүлээн авч, ашиглаж байна.

Бүгд найрамдах Франц улсын "Десотел групп" нь 1932 оноос одоог хүртэл өөрийн автомашин, тоног төхөөрөмжийн сайжруулалтыг тасралтгүй хөгжүүлж, сүүлийн 12 жилийн хугацаанд Парис, Испани, Герман, Франц, Шотланд, Африкийн Алжер, Сенегал, Морокко, Лива, Турк, Хойд Америкийн Чили, Гаяна, Бразил, Азийн Хятад, Вьетнам, Монгол, Ирак гэх мэт 40 гаруй орон, нисэх онгоцны буудал, цэргийн баазуудад нийлүүлсээр байгаа юм.

Монгол Улсад нийлүүлсэн автомашинууд нь дунд зэргийн уур амьсгалтай орчны агаарын хэм нь -40+400С-т үүрэг гүйцэтгэх боломжтой.



Гал унтраах, өндрөөс аврах автомеханик шат EPC 32 PRX-B хосолсон хөдөлгөөнт эргэдэг шат нэмэлт аврах төхөөрөмж, хувьсах (X) тулгуур, аврах сагсаар тоноглогдсон.

Газрын гадаргуугаас аврах сагсны шал хүртэлх хэмжээ: 31 м  
Хамгийн их өндрийн сунах хязгаар: 32.5 м  
Тэнцвэржүүлэх тулгууруудын сунах хязгаар: 5.4 м  
Тоноглол: Автомат халаагуур, цамхгийн хөдөлгөөний хяналтын мэдээлэх систем  
Аврах сагс болон цамхгийн гүйцэтгэх хөдөлгөөний техникийн үзүүлэлт /маневр/  
Дээш суналт /00 - 750/ 45 сек  
Хураах / 750 - 00/ 45 сек  
Хамгийн урт сунгалт хугацаа 45 сек  
Бүрэн хураагдах хугацаа 45 сек  
Зүүн болон баруун тийш 3600 эргэлт 45 сек



Гал унтраах үндсэн албаны Рено (Renault) D 15 HIGH 4X4 280E3 PTAC 16 Т (D15 модел, 4X4 AWD) автомашин

**Автомашинны загвар:** Renault D15 /4x4/ 280E3  
Хөдөлгүүрийн хүчин чадал: 280 HP  
-Гал унтраах хөөрөг /насос/-ний загвар: TO 3001  
-Гал унтраах хөөрөг /насос/-ний хүчин чадал: 3000 л/мин  
-Усны савны хэмжээ: 4000 литр  
-Хөөс үүсгэгч бодисын савны хэмжээ: 400 литр  
12 бар болон өндөр даралтад 250 литр/минут



Хөөсөөр гал түймэр унтраах тусгай зориулалтын автомашин

**Автомашинны загвар:** Renault K 440 P6X4 HEAVY.34 E3  
Хөдөлгүүрийн хүчин чадал: 320 кВт  
Хурдны хайрцаг: урагш 12, ухрах 3 араа бүхий автомат  
Гал унтраах хөөрөг /насос/-ний загвар: JOHNSTABT  
Хөөсөөр гал унтраах хөөрөг /насос/-ний загвар: ALBANY  
Хөөсөөр гал унтраах хөөрөг /насос/-ний хүчин чадал: 10-600 л/мин, HD5 гидростатик хөтөч  
Гал унтраах хөөрөг /насос/-ний хүчин чадал: 12 бар-д 9000 л/мин  
Суурин лафетны хушуу: STREAM MASTER 2 – 6 бар-д 1000-5700 л/мин, алсын зайн удирдлагатай.  
Сорох хүчин чадал: 3 метр гүнээс 12 бар-д 8000 литр  
Усны савны хэмжээ: 8500 литр, тусгаарлагч болон халаагчтай полиэфир  
Хөөс үүсгэгч бодисын савны хэмжээ: 5100 литр

## ПОЛЬШ



Монгол Улс, Бүгд найрамдах Польш улсын Засгийн газар хоорондын "Гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх" төсөл амжилттай хэрэгжсэн. Гал унтраах үндсэн албаны автомашин, техникийн сэлбэг, хэрэглийг голчлон Европын холбооны орнуудад нийлүүлсэн. Монгол Улсад нийлүүлсэн автомашинуудыг тусгай захиалгаар үйлдвэрлэсэн бөгөөд гал унтраах үндсэн албаны болон тусгай зориулалтын багаж зэвсэглэмжээр тоноглогдсон, эрс тэс уур амьсгалтай орчны агаарын хэм нь -40+400С-т үүрэг гүйцэтгэх боломжтойгоороо онцлог.

## Техник үзүүлэлт:

Үйлдвэрлэсэн компани: Grupa Stolarczyk  
Автомашинны загвар: TLF 4000 AT/MAN 18.280 TGM  
Хөдөлгүүрийн хүчин чадал: 280 HP  
Гал унтраах хөөрөг /насос/-ний загвар: NH 35  
Гал унтраах хөөрөг /насос/-ний хүчин чадал: 40 бар даралтаар 400 л/мин  
Усны савны хэмжээ: 4100 литр  
Хөөс үүсгэгч бодисын савны хэмжээ: 400 литр

## АВСТРИ



Монгол Улс болон Австри улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээрийн төслөөр хүлээн авч, ашиглаж байна. Гал унтраах, өндрөөс аврах автомеханик шат EPC 32 PRX-B хосолсон хөдөлгөөнт эргэдэг шат нэмэлт аврах төхөөрөмж, хувьсах (X) тулгуур, аврах сагсаар тоноглогдсон.

## Техник үзүүлэлт:

-Газрын гадаргуугаас аврах сагсны шал хүртэлх хэмжээ: 31 м  
-Хамгийн их өндрийн сунах хязгаар: 32.5 м  
-Тэнцвэржүүлэх тулгууруудын сунах хязгаар: 5.4 м  
Тоноглол: Автомат халаагуур, цамхгийн хөдөлгөөний хяналтын мэдээлэх систем  
Аврах сагс болон цамхгийн гүйцэтгэх хөдөлгөөний техникийн үзүүлэлт /маневр/  
Дээш суналт /00 - 750/ 45 сек  
Хураах / 750 - 00/ 45 сек  
Хамгийн урт сунгалт хугацаа 45 сек  
Бүрэн хураагдах хугацаа 45 сек  
Зүүн болон баруун тийш 3600 эргэлт 45 сек




СУДАЛГААНЫ АЖИЛ



Тооцоогоор гал түймэр унтраах ажиллагааг тактикийн алдаатай явуулсан тохиолдолд 14 цагийн дараа резервуараас их хэмжээний нефть бүтээгдэхүүн мазут цацагдаж унтраах бие бүрэлдэхүүнд аюул үүсгэх магадлалтай.

# РЕЗЕРВУАР ДАХЬ

## ГАЛ ТҮЙМРИЙН ҮЕД НЕФТЬ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЦАЦАГДАХ АЮУЛЫГ ТОГТООХ



Зураг 1. – Мазут хадгалж буй резервуарын гал түймрийн үед шатах шингэний цацагдах үеийн зураглал

Нефть бүтээгдэхүүн хадгалах резервуарын гал түймрийн үеийн гол аюулын нэг нь цацагдаж гарах үзэгдэл юм. Гадаргуу дээрх халалтын шинж чанараар хялбар авалцан асах болон шатах шингэний шинж чанараар шингэнийг хоёр бүлэгт хувааж болно.

Эхний бүлэг- давхарга дахь температур нь цаг хугацааны явцад бараг өөрчлөгддөггүй шингэнүүдээс бүрддэг (архи, ацетон, бензин, керосин, дизель түлш гэх мэт). Харин шингэний гадаргуу дээрх температур нь буцлах температуртай ойролцоо байдаг.

Хоёрдахь бүлэг (түүхий нефть, бензин, мазут г.м) - удаан хугацаанд шатах чадвартай гадаргуу дээрх шингэний давхарга үүсдэг шингэнүүд.

Резерварт усны давхарга байхгүй тохиолдол гардаг. Гэсэн хэдий ч ус нь (усан дэр) шатамхай шингэнд оршидоо эмульс хэлбэрээр байдаг. Дээд давхаргын зуурамтгай чанар буурснаар усны дусал доош гүний шилждэг. Харин нефть бүтээгдэхүүний зуурамтгай чанар өндөр буюу резервуарын доод хэсэгт усан дэр болон хуримтлагддаг. Энэхүү бүсэд хуримтлагдсан ус нь халж буцалж нефть бүтээгдэхүүний цацагдах үйл явцыг бий болгодог. Усны буцлалт нь эрт явагдах тусам резервуараас нефть бүтээгдэхүүн цацагдах хугацааг хурдасгадаг. Мөн буцлалтын цаг хугацаа нь нефть бүтээгдэхүүний чийгшил, резервуар дахь шингэний түвшний чөлөөт орон зай зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаална. Хэрэв чөлөөт талбайн орон зайн өндөр нь халсан давхаргын зузаанаас хоёр дахин их байвал резервуар дахь нефть бүтээгдэхүүний агууламжийн нэг хувь хүртэл усны агууламжтай гэж үзнэ. Энэ тохиолдолд резервуарын буцалж цацагдах хугацаа нь 45-60 минутын дараа явагдана. Галан бамбарын температур нь 1500 °C хүртэл хална. Дөлний өндөр нь 2-3 дахин их байна.

Гал түймрийн үед резервуар дахь шатах шингэний цацагдах хугацааг тусгай томъёо ашиглан ойролцоох хугацааг тогтоох ёстой бөгөөд гал түймэр унтраах удирдагч нь энэхүү хугацаанд тулгуурлан хүч хэрэгслийг төвлөрүүлэх, хөөсний атак явуулах бэлтгэл бэлэн байдлыг цацагдах хугацаанаас өмнө явуулах шаардлагатайг анхаарах хэрэгтэй.



**Б.ЭНХТУВШИН**  
Онцгой байдлын сургуулийн Гал түймэртэй тэмцэх албаны тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), дэд хурандаа

Резервуар дахь нефть бүтээгдэхүүний цацагдах ойролцоо хугацааг дараах томъёо ашиглан тодорхойлно.

$$t = \frac{H-h}{\theta_{ш} + \theta_{халах}}$$

Үүнд: H – резервуар дахь шингэний өндөр, м;

h – усан дэрний зузаан, м;

$\theta_{ш}$  – шатах шугаман хурд, м/цаг;

$\theta_{халах}$  – халах хурд, м/цаг.

Дээрх резервуарын гал түймрийн үед нефть бүтээгдэхүүн цацагдах аюулыг дүгнэж үзэхэд гал түймэр унтраах удирдагч нь дараах нефть бүтээгдэхүүн буцлах шинж тэмдгийг заавал мэдэх байх ёстой үүнд:

- шаталтын үед галан бамбарын дөлний өнгө өөрчлөгдөх;

- хэт халалтын улмаас дуу чимээ гарч эхлэх;

- резервуарын босоо хананд хэт халалтын улмаас цайралтын талбай нэмэгдэх.

Гал түймэр унтраах удирдагч гал түймрийн үед цаг хугацаа алдах, унтраах ажиллагаанд тактикийн алдаа гарсан тохиолдолд резервуар дахь нефть бүтээгдэхүүн цацагдсан тохиолдолд гал түймэр унтраах хүн, хүч хэрэгсэл бүхэлдээ аюул шууд өртөх өндөр эрсдэлтэйг онцгой анхаарах шаардлагатай. Иймээс аливаа нефть бүтээгдэхүүн хадгалах агуулахын резерварт гарсан гал түймрийн үед уг усан дэрнээс үүсэх аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ бол хөргөлтийг амжилттай зохион байгуулах үйл ажиллагаа гэдгийг гал түймэр унтраах бүх түвшний удирдлага онцгой анхаарах хэрэгтэй.

### Нефть бүтээгдэхүүн хадгалах резерварт гарсан гал түймрийн үед үүсэх болзошгүй цацагдах хугацааг тодорхойлох жишээ бодлого

Өгөгдөл:  
Хадгалж буй нефть бүтээгдэхүүний төрөл: мазут  
Резервуар дахь шатах шингэний өндөр (H): 940 см  
Резервуар дахь усан дэрний өндөр (h): 150 см  
Резервуарын эзлэхүүн ( $V_{резервуар}$ ): 1000 м<sup>3</sup>.

Резервуарын диаметр ( $d_{резервуар}$ ): 12 м.

Резервуарын өндөр ( $H_{резервуар}$ ): 9,4 м

Даалгавар: Резервуарын гал түймрийн шаталтын талбай  $S_{шаталтын}$ , галан бамбарын өндөр  $h_{бамбар}$ , дулаан ялгаралтын хэмжээ  $Q_{дулаан}$ , резервуар дахь нефть бүтээгдэхүүний цацагдах ойролцоох хугацаа t зэргийг тооцоолох.

Бодолт:

1. Резервуарын шаталтын талбайг шатах шингэний толин гадаргуугаар тооцно.

$$S_{шаталтын} = \pi \cdot r^2 = \frac{\pi d^2}{4} = \frac{3,14 \cdot 12^2}{4} = 113,04 \text{ м}^2$$

2. Галан бамбарын өндөр нь резервуарын диаметртээ шууд хамааралтай байдаг. Үүнийг дараах томъёогоор тодорхойлно.

$$h_{бамбар} = K \cdot d_{резервуар} = 1,5 \cdot 12 = 18 \text{ м}$$

3. Дулаан ялгаралтын хэмжээг дараах томъёогоор тодорхойлно.

$$Q_{дулаан} = \pi \cdot V_{макс} \cdot Q_{качлол} \cdot S_{резервуар} = 0,85 \cdot 2,93 \cdot 41900 \cdot 113,04 = 11795944 \text{ кДж/ц}$$

$$Q_{дулаан} = \frac{11795944}{3600} = 3276,65 \text{ кДж/с}$$

4. Резервуар дахь нефть бүтээгдэхүүний цацагдах ойролцоох хугацааг дараах томъёо ашиглан тодорхойлно.

$$t = \frac{H-h}{\theta_{ш} + \theta_{халах}} = \frac{940-150}{13+12} = \frac{790}{25} = 14,36 \text{ цаг}$$

Хариулт: Резервуарын гал түймрийн шаталтын талбай  $S_{шаталтын} = 113,04 \text{ м}^2$ ;

Галан бамбарын өндөр  $h_{бамбар} = 18 \text{ м}$ ;

Дулаан ялгаралтын хэмжээ  $Q_{дулаан} = 3276,65 \text{ кДж/с}$ .

Резервуар дахь нефть бүтээгдэхүүний цацагдах ойролцоох хугацаа  $t = 14,36$  цаг. Зураг 1- т үзүүлэв.

### Тооцооны үр дүн:

Хэрэв нефть бүтээгдэхүүн хадгалах ган босоо сав резервуарын гал түймрийн үед унтраах ажиллагааг тактикийн ямар нэгэн алдаатай зохион байгуулсан тохиолдолд нефть бүтээгдэхүүн цацагдах аюул үүсэх бөгөөд энэхүү цацагдах аюулыг дөрвөн үе шаттай тооцооны үр дүнд боловсруулдаг. Тооцоогоор гал түймэр унтраах ажиллагааг тактикийн алдаатай явуулсан тохиолдолд 14 цагийн дараа резервуараас их хэмжээний нефть бүтээгдэхүүн мазут цацагдаж унтраах бие бүрэлдэхүүнд аюул үүсгэх магадлалтай байгааг тактикийн тооцоогоор үзүүлэв.

Уншигчдад анхааруулахад нефть бүтээгдэхүүний төрөл буюу хялбар авалцан асах болон шатах шингэний төрлөөс хамаарч цацагдах хугацаа мөн харилцан адилгүй тодорхойлогдоно. Харин цацагдах аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь гал түймэр унтраах ажиллагааны явцад хөргөлтийг зөв зохион байгуулах явдал юм.

МЭДЭЭЛЭЛ

## ШИГШЭЭ БАГИЙН ТАМИРЧИД МОНГОЛ УЛСЫН ДЭЭД АМЖИЛТЫГ ШИНЭЧЛЭН ТОГТООВ



БНТУ-ын Истанбул хотод өнгөрсөн наймдугаар сарын 31-нээс есдүгээр сарын 6-ны хооронд дэлхийн аврагч, гал сөнөөгчдийн 18 дахь удаагийн насанд хүрэгчдийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн амжилттай болж өндөрлөлөө.

Тус тэмцээний гурав дахь өдөр зохион байгуулагдсан 4x100 м-ийн буухиа тэмцээний төрөлд манай шигшээ багийн I багийн тамирчид 57:77 секундний амжилтаар Монгол Улсын дээд амжилтыг шинэчлэн тогтоов. Мөн нийслэлийн Онцгой байдлын газрын Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах ИТУА/ X ангийн салааны захирагч, дэслэгч Г.Цогтбаяр, тус ангийн аврагч, гал сөнөөгч ахлах ахлагч Б.Буянбат, Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын ГТУА-22 дугаар ангийн аврагч, гал сөнөөгч дэд ахлагч С.Төрбат, Булган аймгийн Онцгой байдлын газрын ГТУА-20 дугаар ангийн аврагч, гал сөнөөгч ахлах ахлагч Б.Мөнх-Эрдэнэ нар олон улсын хэмжээний мастер цолны болзол хангасан байна.

Энэ төрөлд Монгол Улсын баг VI байр эзэлсэн бол, I байрыг Узбекистан улсын баг тамирчид 55:06, II байрыг Хятадын баг тамирчид 55:50, III байрыг Казакстан улсын баг тамирчид 57:02 секундний амжилтаар тэргүүлээ.



# ГАДААД ХАРИЛЦАА ӨРГӨЖИН ТЭЛСЭЭР...

**Гал түймэртэй тэмцэх чиглэлээр гадаад харилцаа 1990 оны дунд үеэс идэвхтэй хөгжиж, Засгийн газрын зөвшөөрлийн дагуу 1996 онд Азийн олон улсын галын байгууллагын дарга нарын, 2000 онд дэлхийн олон улсын Галын байгууллагын дарга нарын, 2002 онд Галын инженерүүдийн холбоонд гишүүнээр элсэж үйл ажиллагаанд нь тасралтгүй идэвхтэй оролцож ирсэн.**

## УУЛЗАЛТ ЗӨВЛӨГӨӨН, ХАМТЫН АЖИЛЛАГАА

1935 он  
ЗСБНХУ-ын Галын байгууллагын ажилтан сургагч багш мэргэжилтэн Ю.А.Родионов, А.В.Кудряшев, М.Л.Кулаков  
1973-1986 он  
Социалист орнуудын Галын байгууллагын удирдах ажилтнуудын уулзалт зөвлөгөөн /1973 он Болгар улс, 1975 он Герман улс, 1977 он Чехословак, 1979 он ЗХУ-ын Сочи хот, 1981 он Унгар улс, 1984 он ЗХУ-ын Минск хот, 1986 он Польш улс  
1996-2016 он  
Азийн олон улсын Галын байгууллагын дарга нарын холбоо / Япон/

Япон, Солонгос, Малайз, Сингапур, Тайланд, Энэтхэг, Гонконг, Тайвань, Индонез улсад зохион байгуулсан холбооны бага хуралд Д.Хишигбаатар, О.Ганхуяг, Д.Батбаатар, С.Залуухуу нарын 22 алба хаагч оролцож гишүүнээр элссэн.

2000-2012 он  
Дэлхийн олон улсын галын байгууллагын дарга нарын холбооны хуралд Д.Хишигбаатар, Н.Боорой, Д.Батбаатар, О.Ганхуяг, К.Султаминкарим, С.Залуухуу нар оролцжээ.

2000 он  
Миссури мужийн Канзас хот, 2002 он Техас мужийн Даллас хот, /2012 он АНУ-ын Чикаго хотод зохион байгуулсан холбооны бага хуралд Д.Хишигбаатар, Н.Бойрой, О.Ганхуяг, Д.Батбаатар, К.Султаминкарим, С.Залуухуу нар оролцож гишүүнээр элссэн/

2002 он  
Галын инженерүүдийн холбоо /2000 он Англи улсын Манчестер хотод зохион байгуулсан холбооны бага хуралд Д.Хишигбаатар, Л.Пүрэвхүү нар оролцож гишүүнээр элссэн/

2004 он  
Солонгос улсын Дегу хотод зохион байгуулагдсан Азийн галын шинжлэх ухаан технологийн бага хуралд хурандаа Ж.Ганбаатар оролцсон.

2004 он  
Тайван улсад зохион байгуулагдсан Азийн олон улсын галын байгууллагын дарга нарын 22 дугаар бага хуралд хурандаа Д.Хишигбаатар ахлагчтай 12 төлөөлөгч оролцсон.

2009 он  
ОХУ-д зохион байгуулагдсан "Ой, хээрийн түймрийг унтраах команд штабын сургууль", БНХАУ-ын ӨМАЗО-д зохион байгуулагдсан "Галын байгууллагын техник төхөөрөмжийн хөгжил", Буриад улсад зохион байгуулагдсан Олон улсын бага хуралд ГТТГ-ын дарга хурандаа С.Залуухуу тэргүүтэй төлөөлөгчид оролцсон.

2010 он  
ОХУ-ын Онц байдлын яамнаас зохион байгуулсан олон улсын "Хил дамнанас ой, хээрийн түймэр, тулгамдсан асуудал" сэдэвт уулзалтад хурандаа С.Залуухуу оролцсон.

2010 он  
Япон улсад зохион байгуулагдсан "Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ" зөвлөгөөнд хурандаа Д.Бямбацогт оролцсон.

2012 он  
Турк улсын Анталья хотод зохион байгуулагдсан Олон улсын гал сөнөөгч, аврагчийн спортын холбооны XIII бага хуралд Гал түймэртэй тэмцэх газрын ахлах мэргэжилтэн хурандаа Г.Баттөгс, Улсын шигшээ багийн дасгалжуулагч дэд хурандаа С.Баттөмөр нар ажиглагчаар оролцсон.

2015 он  
Австри улсын Розенбаур компанид Гал унтраах, аврах ажиллагааны зориулалтын автомашин техникийн хүчин чадал, иж бүрдлийг шалгах ажлын хэсэгт Гал түймэртэй тэмцэх газрын ахлах мэргэжилтэн, хошууч Ц.Нямбаяр ажилласан.

2017 он  
Бүгд найрамдах Беларусь улсын Минск хотноо зохион байгуулагдсан "MILEX 2017" найм дахь удаагийн олон улсын



үзэсгэлэнд Гал түймэртэй тэмцэх газрын дарга, хурандаа С.Залуухуу оролцсон.

2017 он  
БНХАУ-ын Бээжин хотын Ойн захиргааны улсын академид "Хөрш орнуудын ойн түймрээс хамгаалах ахлах мэргэжилтэн нарын семинар"-т Гал түймэртэй тэмцэх газрын Гал унтраах хэлтсийн дарга, дэд хурандаа Ц.Нямбаяр Баян-Өлгий, Булган, Дархан, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ, Хөвсгөл, Хэнтий аймгийн Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга найман албан хаагч, Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн Ч.Ананда нарын нийт есөн алба хаагч оролцсон.

• Бүгд найрамдах Беларусь улсын Минск хотноо зохион байгуулагдсан "Монгол, Беларусын худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааны хамтарсан комиссын IV хуралдаан"-нд Гал түймэртэй тэмцэх газрын дарга, хурандаа С.Залуухуу оролцсон

• Оросын Холбооны улсын Москва хотноо зохион байгуулагдсан "Ойг түймрээс хамгаалах тухай" Монгол Улс,ОХУ-ын Засгийн газар хоорондын байгуулсан хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах хамтарсан комиссын хуралдаанд Гал түймэртэй тэмцэх газрын Гал унтраах хэлтсийн дарга, дэд хурандаа Ц.Нямбаяр оролцсон.

2018 он  
Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар,ОХУ-ын Онц байдлын яамны Бүгд найрамдах Буриад улс дахь ерөнхий газар хоорондын 2018 онд хамтран ажиллах төлөвлөгөөг батлах уулзалт Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд 2018 оны дөрөвдүгээр сарын 25-нд зохион байгуулагдсан

• Япон улс, Токио хотод Азийн галын дарга нарын Олон улсын холбооноос зохион байгуулсан "Азийн галын дарга нарын олон улсын холбооны 30 дугаар хурал"-д Гал түймэртэй тэмцэх газрын дарга, хурандаа Ц.Нямбаяр 2018 оны тавдугаар сарын 30-наас зургаадугаар сарын 2-ны өдрүүдэд оролцсон.

• ОХУ-ын Саратов хотод 2018 оны арваннэгдүгээр сарын 21-24-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Олон улсын аврагч, гал сөнөөгчдийн спортын холбооны 19 дүгээр хуралд Гал түймэртэй тэмцэх газрын дарга, хурандаа Ц.Нямбаяр оролцсон

2019 он  
Бүгд найрамдах Польш улсын Варшав хотод Монгол Улс болон Бүгд найрамдах Польш улсын Засгийн газар хоорондын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжиж буй "Гал түймэртэй тэмцэх техник, тоног төхөөрөмжийг сайжруулах", "Гамшгийн үеийн хөдөлгөөнт хээрийн эмнэлэг-2 иж бүрдэл" төслүүдийн хэрэгжилтийн үйл явцтай танилцах ажлын хэсэгт Гал түймэртэй тэмцэх газрын дарга, хурандаа Ц.Нямбаяр, Гал түймэртэй тэмцэх газрын Гал унтраах хэлтсийн мэргэжилтэн, ахлах дэслэгч Э.Амгалан нар 2019 оны нэгдүгээр сарын 25-29-ний хооронд оролцсон.

2019 он  
БНХАУ-ын Бээжин хотод "Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд найрамдах Хятад ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг Хятадын талтай хэлэлцэн тохиролцох хэлэлцээрийн багийн уулзалт" зохион байгуулагдсан. Уг ажлын хэсэгт Гал түймэртэй тэмцэх газрын дарга, хурандаа Ц.Нямбаяр 2019 оны гуравдугаар сарын 10-13-ны өдрүүдэд ажилласан.

• БНСУ-ын Дэгү хотод 2019 оны дөрөвдүгээр сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Олон улсын галын аюулгүй байдлын үзэсгэлэн яармаг болон Солонгосын галын хүрээлэнгийн 16 дахь удаагийн олон улсын бага хуралд Гал түймэртэй тэмцэх газрын Гал унтраах хэлтсийн дарга, дэд хурандаа Г.Галбадрах оролцсон.

2021 он  
Гал түймэртэй тэмцэх газрын дарга, хурандаа Ц.Нямбаяр, Гал түймэртэй тэмцэх газрын Гал унтраах хэлтсийн мэргэжилтэн, ахмад Б.Билгүүн, нийслэлийн Онцгой байдлын газрын мэргэжилтэн, ахмад Б.Сэрдамба, 115 дугаар ангийн Тээврийн салбарын тусгай зориулалтын автомашины хэсгийн дарга, ахмад Д.Ганбилэг нар 2020 оны зургаадугаар сарын 15-23-ны өдрүүдэд Бүгд найрамдах Беларусь улсын Борисов хот дахь "Пожснаб" компанид зочилж, төслөөр нийлүүлэгдсэн автомеханик шатны автомашины хугацаат техник үйлчилгээ хийх мөн цаашид хоёр дахь шатны төслийг хэрэгжүүлэх боломж, хамтын ажиллагааны талаар санал солилцсон.

• Гал түймэртэй тэмцэх газрын дарга, хурандаа Ц.Нямбаяр, Гал түймэртэй тэмцэх газрын Гал унтраах хэлтсийн мэргэжилтэн, ахмад Б.Билгүүн нар 2020 оны зургаадугаар сарын 23-30-ны өдрүүдэд Бүгд найрамдах Франц улсын Леон хот дахь "Десотел" группын "Невориз" дахь автомашины үйлдвэрт зочилж, Монгол Улсад нийлүүлэх үйлдвэрлэлийн гал түймэр унтраах хөөсний автомашины үйлдвэрлэлийн явц, нийлүүлэх тоног төхөөрөмж, хамгаалах хувцас хэрэгсэлтэй танилцсан.

• Гал түймэртэй тэмцэх газрын дарга, хурандаа Ц.Нямбаяр, Гал түймэртэй тэмцэх газрын Гал унтраах хэлтсийн ахлах мэргэжилтэн, хошууч Э.Энх-Амгалан нар 2020 оны есдүгээр сарын 7-21-ний өдрүүдэд Бүгд найрамдах Франц улсын Леон хот дахь "Десотел" группын "Невориз" дахь автомашины үйлдвэрт зочилж, Монгол Улсад нийлүүлэх үйлдвэрлэлийн гал түймэр унтраах хөөсний автомашины үйлдвэрлэлийн явц, автомашинуудад нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийг шалгах, хамгаалах хувцас хэрэгсэлтэй танилцсан.

• Гал түймэртэй тэмцэх газрын дарга хурандаа Ц.Нямбаяр, Гал түймэртэй тэмцэх газрын дарга бэлтгэл хурандаа Г.Баттөгс нар Бүгд найрамдах Узбекистан улсын Ташкент хотноо 2021 оны арваннэгдүгээр сарын 11-17-ны өдрүүдэд зохион байгуулсан "Олон улсын гал сөнөөгч, аврагчдын холбооны XXII олон улсын хурал"-д оролцсон.

2022 он  
Гал түймэртэй тэмцэх газрын дарга хурандаа Ц.Нямбаяр, Бүгд найрамдах Турк улсын Истанбул хотноо 2022 оны арваннэгдүгээр сарын 11-17-ны өдрүүдэд зохион байгуулсан "Олон улсын гал сөнөөгч, аврагчдын холбооны XXIII олон улсын хурал"-д оролцсон.

2023 он  
Хил орчмын ой, хээрийн гал түймэртэй тэмцэх талаар хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Хятад, Монголын хооронд ой, хээрийн гал түймрийн менежментийн үйл ажиллагааны гарын авлага" боловсруулах ажилд ГТТГ-ын дарга, хурандаа Ц.Нямбаяр ахлуулсан ажлын хэсэг энэ оны зургаадугаар сарын 20-23-ны өдрүүдэд ӨМӨЗО-ны Шилийн хотод ажилласан.

# ГАДААДАД МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ АЛБА ХААГЧДЫН ТОО ЖИЛ ИРЭХ БҮР НЭМЭГДЭЖ БАЙНА

1956 он  
ЗСБНХУ-ын Дотоод явдлын яамны Ленинград хотын Галын техникийн дунд сургуулийг 1956-1990 он хүртэл 181 алба хаагч суралцаж галын техникч мэргэжил эзэмшжээ.

1960 он  
ЗСБНХУ-ын ДЯЯ-ны Москва хот дахь Галын инженер-техникийн дээд сургуульд 1990-2000 он хүртэл 76 алба хаагч суралцаж галын аюулгүй байдлын инженер мэргэжил эзэмшсэн байдаг.

1982 он  
ЗСБНХУ-ын ДЯЯ-ны Ленинград хотын Галын техникийн дунд сургуульд гал унтраах ангийн дарга нарын мэргэжил дээшлүүлэх 45 хоногийн дамжаа 20 алба хаагч хамрагдав.

1986 он  
ЗСБНХУ-ын ДЯЯ-ны Москва хот дахь Галын инженер-техникийн дээд сургуульд галын байгууллагын удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх 45 хоногийн дамжаанд 20 алба хаагч хамрагдсан.

1992 он  
Бүх Холбоотын Галын аюулгүй байдлын судалгааны институтэд галын шинжлэх нарын 14 хоногийн дамжаанд дөрвөн алба хаагч мэргэжил дээшлүүлээ.

1997-2000 он  
Япон улсын Гал гамшгийн

удирдлагын агентлагийн Захиргааны удирдлага хоёр алба хаагч, Галын аюулаас урьдчилан сэргийлэх техник сургалтад хоёр алба хаагч 45 хоног суралцаж мэргэжил дээшлүүлэв.

2000-2004 он  
АНУ, Канад, Япон, Малайз, Сингапур, Солонгос улсын галын байгууллагад 14 хоног туршлага судалж мэргэжил дээшлүүлэх курст зургаан алба хаагчийг хамруулав.

2002 он  
Тайвань улсын Галын аюулаас хамгаалах газрын сургалтын төвд гал унтраах тусгай зориулалтын автомашины ашиглалт, засвар үйлчилгээний чиглэлээр гурван алба хаагч, суралцаж мэргэжил дээшлүүлсэн.

2003 он  
Унгар улсын Галын аюулаас хамгаалах ерөнхий газрын сургалтын төвд гал түймрийн шалтгаан нөхцөлийг тогтоох чиглэлээр нэг сарын сургалтад Гал түймэртэй тэмцэх шинжилгээ судалгааны хэлтсийн дөрвөн алба хаагч хамрагдаж мэргэжил дээшлүүлэв.

2008 он  
ОХУ-ын Санкт-Петербург хотын Галын их сургуульд,гал түймрийн шалтгаан нөхцөлийг тогтоох чиглэлээр 14 хоногийн сургалтад нэг алба хаагч

мэргэжил дээшлүүлжээ. 2009-2010 он  
ОХУ-ын Онц байдлын яам, Гал эсэргүүцэх албаны академид хурандаа Д.Эрдэнэбилэг ахлагчтай 14 салааны захирагч ОХУ-ын ДЯЯ-ны Дорнод Сибирийн академид 16 гал түймрийн улсын хяналтын байцаагч нар мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байна.

2010 он  
Малайз зохион байгуулсан "Хийн болон нефть бүтээгдэхүүнд гарсан гал түймрийг унтраах арга зүй" сургалтад ахмад Х.Сүхбаатар оролцсон.

2010 он  
Иркутск хотод болсон мэргэжил дээшлүүлэх сургалтад хошууч Д.Батбаатар оролцлоо.

2009-2013 он  
ОХУ-ын Москва, Санкт-Петербург, Иркутск хотын Гал эсэргүүцэх албаны академи, Галын их сургуульд 14 хоногийн хугацаатай гал унтраах ангийн дарга, гал түймрийн улсын хяналтын байцаагч нарын мэргэжил дээшлүүлэх сургалтад нийтдээ 47 алба хаагч хамрагджээ.

2013-2014 он  
Япон улсын Саппоро хотын Галын газрын сургалтын төвд гал унтраах арга барилыг дээшлүүлэх сэдэвт сургалтад нийтдээ 30 алба хаагч хамрагдсан.

2016 он  
Малайз улсын Селангор мужийн Куала кубу бару хотод барилгын гал унтраах олон улсын 12 хоногийн сургалтад Гал түймэртэй тэмцэх газрын ахлах мэргэжилтэн, хошууч Ц.Нямбаяр хамрагдсан.

2017 он  
Монгол Улс, БНХАУ-ын гал түймэртэй тэмцэх хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор БНХАУ-ын Хэбэй мужийн Ланфан хотноо зохион байгуулсан 20 өдрийн сургалтад ГТТГ-ын ахлах мэргэжилтэн, хошууч Г.Галбадрахаар ахлуулсан НОБГ, Ховд, Хэнтий, Хөвсгөл, Сүхбаатар, Завхан, Булган, Сэлэнгэ, Дархан-Уул, Өмнөговь, Орхон аймгийн Онцгой байдлын газраас нийт 20 албан хаагч оролцлоо.

2017 он  
Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотноо зохион байгуулагдсан "Азийн ойн түймрийн менежментийн сургалт-2017" Бүгд найрамдах Солонгос улс, НҮБ хамтран зохион байгуулсан сургалтад Гал түймэртэй тэмцэх газрын Гал унтраах хэлтсийн мэргэжилтэн, хошууч С.Галтзул оролцов.

2017-2018 он  
Энэтхэг улсад Англи хэлний мэдлэг дээшлүүлэх сургалтад Гал түймэртэй

тэмцэх газрын Гал унтраах хэлтсийн мэргэжилтэн, хошууч С.Галтзулын дөрвөн сарын сургалтад хамрууллаа..

2018 он  
Бүгд найрамдах Солонгос улсын Сөүл хотод Азийн ойн гал түймэртэй тэмцэх байгууллагаас зохион байгуулсан "Ойн гал түймэр гарах шалтгаан, онцлог, шалтгаан нөхцлийг тогтоох" сэдэвт долоо хоногийн сургалтад Гал түймэртэй тэмцэх газрын Гал унтраах хэлтсийн мэргэжилтэн, хошууч С.Галтзул хамрагдав.

2019 он  
Арабын нэгдсэн Эмират улсын Иргэний хамгаалалтын академид 2019 оны арванхоёрдугаар сарын 8-ны өдрөөс арванхоёрдугаар сарын 14-ний өдрүүдэд зохион байгуулсан "Гал түймэр унтраах эрэн хайх сэдэвт Олон улсын сургалт"-д Гал түймэртэй тэмцэх газрын дарга, хурандаа Ц.Нямбаяр оролцов.

Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймэр унтраах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн, хошууч Б.Отгонзаяа, 2022 оны есдүгээр сараас 12 дугаар сар дуустал БНФУ-ын Ундэсний галын офицерын сургуулийн "Гал түймэр унтраах удирдагч"-ийн сургалтад хамрагдсан.

# МОНГОЛД АШИГЛАЖ БАЙГАА ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ ТУСГАЙ ТОНОГЛОЛ БҮХИЙ АВТОМАШИН ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

2002 он Тайвань улсын буцалтгүй тусламжийн хүрээнд үндсэн албаны гурав, тусгай албаны хоёр автомашин орж ирсэн  
2003 он АНУ-ын буцалтгүй тусламжаар тусгай албаны автомашин орж ирэв.

• Япон улсын буцалтгүй тусламжаар "Улаанбаатар хотын гал түймэртэй тэмцэх техник, тоног төхөөрөмж, холбооны хэрэгслийг шинэчлэн сайжруулах" 6.9 сая ам долларын өртөг бүхий нэг төслөөр дөрвөн төрлийн 17 ширхэг гал түймэр унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлсэн.



хэрэгслийн үйлдвэрүүдтэй танилцах ажлын айлчлал хийжээ. Айлчлалын үр дүнд "Ой хээрийн түймэртэй тэмцэх чадавхыг бэхжүүлэх" чиглэлээр нэг сая ам.долларын өртөг бүхий төсөл боловсруулж Сангийн яаманд хүргүүлэн БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хүрээнд санхүүжүүлэхээр шийдвэрлэжээ.

2016 он

БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хүрээнд "Ой хээрийн түймэртэй тэмцэх чадавхыг сайжруулах" хоёр тэрбум төгрөгийн өртөг бүхий төслөөр зургаан ширхэг гал түймэр унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлсэн.

2017 он

Япон улсын буцалтгүй тусламжийн хүрээнд "Гал түймэртэй тэмцэх техник, тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах"

гал түймэр унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэгдсэн.

• Австрали улсын буцалтгүй тусламжаар "Сэлэнгэ, Хэнтий аймгийн зарим сумдад Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг байгуулах" 30 мянган австрали долларын өртөг бүхий есөн төрлийн 104 ширхэг хувцас, хэрэглэл нийлүүлсэн.

2020 он

Беларусь улсын экспортын зээлийн хүрээнд "Онцгой байдлын албаны гамшигтай тэмцэх чадавхыг сайжруулах" төслөөр 15 сая еврогийн өртөг бүхий 14 төрлийн 71 (Гал түймэр унтраах үндсэн албаны-40, тусгай албаны-12, туслах албаны хоёр, бусад төрлийн-17) ширхэг гал түймэр унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлсэн.



2008 он

Унгар улсын буцалтгүй тусламжийн хүрээнд "Туршилт шинжилгээний багаж хэрэгслийг шинэчлэн сайжруулах, галын шалтгаан нөхцөлийг тогтоох, чадавхыг дээшлүүлэх" 120 мянган ам.долларын өртөг бүхий төсөл хэрэгжүүлэв.



2013 он

Япон улсын буцалтгүй тусламжаар "Гал түймэртэй тэмцэх техник, тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах" 10 сая ам.долларын өртөг бүхий II дахь төслөөр таван төрлийн 22 ширхэг гал түймэр унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлсэн.

2014 он

Гал унтраах техникийн хүчин чадлыг дээшлүүлэх зорилгоор Монгол, Австри улсын Засгийн газар хооронд байгуулсан хөнгөлөлттэй зээлийн хүрээнд гал унтраах техник тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах таван сая еврогийн өртөг бүхий гал унтраах орчин үеийн өндөр хүчин чадалтай 16 тусгай зориулалтын автомашиныг нийлүүлэх төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар дэмжүүлсэн бөгөөд ОБЕГ, Австри улсын "Rozen Bauer" компанитай хамтран хэрэгжүүлэх гэрээнд гарын үсэг зуржээ.

450 мянган ам долларын өртөг бүхий III дахь төслөөр 837 ширхэг гал түймэр унтраах тусгай зориулалтын автомашины сэлбэг нийлүүлэгдсэн.

2018 он

Польш улсын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд "Онцгой байдлын албаны гал түймэртэй тэмцэх техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх" гурван сая еврогийн төслөөр гурван төрлийн 15 ширхэг

2021 он

Монгол, Франц улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн хүрээнд "Онцгой байдлын байгууллагын гал түймэртэй тэмцэх чадавхыг дээшлүүлэх" төслөөр 15 сая еврогийн өртөг бүхий дөрвөн төрлийн 42 ширхэг гал түймэр унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэгдсэн.



2015 он

Хил орчмын бүсийн ой, хээрийн түймэртэй тэмцэх талаарх Монгол, Хятад улсын хамтарсан комиссын хоёрдугаар уулзалт, хамтын ажиллагааны хүрээнд ОБЕГ-ын ГТТГ-ын дарга, хурандаа С.Залуухүүгээр ахлуулсан ажлын хэсэг БНХАУ-ын Ойн улсын хорооны Ойн түймэртэй тэмцэх газар түүний харьяа салбар ангиуд дээр удирдлагын түвшинд туршлага судлах, ойн түймэр унтраах багаж



